Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөр

Гадаад харилцааны яам

2021 оны жилийн эцэс

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2021 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
НЭГ. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО							
1	1.1.8. Гадаад улсад байгаа иргэнээ татан авах ажлыг эрчимжүүлнэ.	1. КОВИД-19-ийн улмаас хүнд нөхцөлд байгаа гадаадад гацсан Монголчуудыг татан авах ажиллагаанд олон улсын байгууллагатай хамтран ажиллана.	2020 - 2021	188.8 сая төгрөг- Иргэдэд туслах сангаас, 120,2 сая төгрөгийг УОК-оос төвлөрүүлсэн 300 сая төгрөгийн үлдэгдэлээс зарцуулсан.	220 хүн эх орондоо ирсэн байна.	Тайлангийн хугацаанд, шинэ Засгийн газар байгуулагдсан даруйд гадаадаас нутаг буцах хүсэлтэй иргэдээ эх оронд нь шуурхай ирүүлэхэд онцгойлон анхаарч ажиллав. 2021 оны эхэнд эх орондоо яаралтай ирэх хүсэлт гаргасан 2692 иргэн байсан бөгөөд энэ хугацаанд бүрэн татан авсан байна. Цар тахал эхэлснээс хойш агаарын хил нээх хүртэл буюу 2020.02.01-2021.05.31-ний хооронд агаарын замаар 183 нислэг үйлдэж 29543, Монгол-Хятадын боомтоор 4301, Монгол-Оросын боомтоор 2516, нийт 36360 Монгол иргэнээ эх оронд нь ирүүлэх ажлыг зохион байгуулсан байна. Энэ онд 2021.01.01-2021.12.31-ний хооронд Монгол Улсын 44906 иргэн эх орондоо ирсэн байна. 2021 оны 3 дугаар сараас эхлэн Монгол Улсын агаарын хилийг нээх бэлтгэл ажлын хүрээнд БНСУ болон Турк Улсын агаарын тээврийн компаниудын нислэгийг сэргээх асуудлаар уулзалт, яриа хэлэлцээ хийж, үүний үр дүнд Korean Air, Asiana, Turkish Airlines, Air Busan зэрэг агаарын тээврийн компаниуд нислэг үйлдэж эхэлсэн. 2021 оны 1 дүгээр сард 2, 2 дугаар сард 6, 3 дугаар сард 19, 4 дүгээр сард 16, 5 дугаар сард 16, 6 дугаар сард 29, 7 дугаар сард 46	100%

						нислэг, 8 дугаар сард 28, 9 дүгээр сард 29, 10 дугаар сард 39, 11 дүгээр сард 39, 12 дугаар сард 61 нислэг үйлдсэн. Иргэдэд үзүүлсэн санхүүгийн дэмжлэг, туслалцаа: 2021 оны байдлаар хилийн чанадад байгаа “Монгол Улсын иргэдэд туслах сан”-гаас 56 өргөдөл, хүсэлтэд 188,8 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн байна. Тус санд УОК-оос төвлөрүүлсэн 300 сая төгрөгөөс энэ онд 280 иргэнд тусгаарлах байрны зардал болон санхүүгийн бусад дэмжлэг үзүүлэхэд нийт 120,2 сая төгрөгийн тусламжийг (нислэгийн тийз, тусгаарлалтын зардал, бичиг баримтын төлбөр зэрэг) үзүүлсэн байна.	
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
2	2.6.3. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, үндэсний агуулгатай инновац шингэсэн соёлын бүтээлч үйлдвэрлэл-инновацын салбарыг хөгжүүлж, монгол брэндийг бий болгож, соёл, урлагийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	1. Монгол хэл, бичиг, соёлыг дэлхий дахинд түгээн дэлгэрүүлэх "Монголын соёлын төв"-ийг их дээд сургуулиуд, эрдэм шинжилгээний байгууллагуудыг түшиглэн байгуулна.	2021 - 2025		Гадаадад монголын соёлын төвийг үе шаттай байгуулах талаар судалгаа хийж, шийдвэрийн төслийг боловсруулж, шаардагдах төсвийг батлуулна.	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлого болон “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Дэлхийн Монголчууд-II”, “Монгол Үндэстний үнэлэмж” цогц арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлэх тухай заасны дагуу Гадаад харилцааны сайдын 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/51 дугаар тушаалаар “Дэлхийн Монголчууд-II” цогц арга хэмжээг баталсан. Хилийн чанадад “Монголын соёлын төв” байгуулах ажлын хүрээнд улс орнууд өөрийн нутагтаа гадаад орны “соёлын төв” байгуулах асуудлыг эрх зүйн хувьд хэрхэн зохицуулдаг талаар судалгаа хийж ирүүлэх чиглэлийг 2020 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн Е/11/20/363 тоот цахимаар нийт ДТГ-уудад хүргүүлэв. 27 ДТГ-аас судалгаа, мэдээлэл ирүүлснийг нэгтгэн, 2021 оны 3 дугаар сарын 2-ны өдрийн Е/11/21/110 тоот цахимаар Соёлын яаманд хүргүүлсэн болно. Хилийн чанад дахь “Монголын соёлын төвүүд” болон монгол сургуулиудын үйл ажиллагааг дэмжих асуудлаар санал боловсруулан Боловсролын ерөнхий хуулийн болон дагалдан гарах хуульд тусгуулахаар	100%

						2021 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 11/2239 албан бичгээр БШУ-ны Сайдад хүргүүлэв. 2021 оны жилийн эцсийн байдлаар 10 улсад 42 монгол хэл, соёлын сургууль болон төв үйл ажиллагаа явуулж буй судалгааг хийж дуусган холбогдох мэдээллийн хамт БШУЯ, Соёлын яаманд хүргүүлэв. Монголын соёлын төвийг байгуулах ажлын хүрээнд БНХАУ-ын нийслэл Бээжин хотод “Монголын соёлын төв”-ийг байгуулах санхүүжилтийн асуудал шийдэгдсэнээр барилгын ажлыг эхлүүлсэн болно. Цар тахлын нөхцөл байдлын улмаас барилга угсралтын ажил удаашралтай байгаа ч 2022 оны намар тус төвийг үйл ажиллагааг нээх чиглэлээр ажиллаж байна.	
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО							
3	3.4.6. Баян-Өлгий, Увс, Ховд, Өвөрхангай, Архангай, Баянхонгор, Өмнөговь, Дорнод, Завхан аймгуудад аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлж, отоглох цэг, авто зам дагуу үйлчилгээний цогцолборуудыг байгуулна. Говийн бүсийн аялал	4. Монголын говьд шинжлэх ухаан, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх MARS-V төслийг хэрэгжүүлнэ. /Survival буюу даван туулж, тэсэж гарах чадвар олгох мэргэжлийнхэн болон сонирхогчдод зориулсан MARS-V академи байгуулах/	2020 - 2024		Сонгогдсон говийн 8 бүсэд нарийвчилсан судалгаа, рекрейцийн үнэлгээ хийх гол хамтрагчдыг татан оролцуулна	Хэрэгжилтийг холбогдох байгууллага гаргана. ОХУ-ын “Роскосмос” байгууллагатай ярилцаж эхэлсэн боловч одоогоор зогсонги байна. Энэхүү арга хэмжээг хариуцагч үндсэн байгууллага нь ГХЯ биш бөгөөд хэрэгжүүлэгч ажлын хэсгээс дэмжлэг хүссэн тохиолдолд холбогдох арга хэмжээг авч ажиллана. Сүүлийн мэдээллээр хөл хорио урт хугацаагаар тогтоож, хил хаагдсантай холбогдуулан үйл ажиллагаа, хэрэгжилт зогсонги байгаа. Нэгэнт УИХ-аас баталсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай Засгийн газрын тогтоол гарч баталсан төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах боломж хомс болохыг ЗГХЭГ-аас мэдээлсэн.	0%

	жуулчлалыг хөгжүүлнэ.						
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО							
4	4.2.5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	3. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.	2021 - 2024		Дүрэмд өөрчлөлт оруулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлнэ. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг хангах талаарх сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг эхлүүлнэ.	Засгийн газрын 2019 оны 272 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дипломат ажилтны сахилгын тусгай дүрэм”-ийг системийн хэмжээнд мөрдөн ажиллаж байгаа бөгөөд уг дүрэм нь дипломат ажилтнууд төдийгүй яам, ДТГ-т ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагч, үйлчилгээ, техникийн ажилтанд хамааралтай. Уг дүрмийн 1.3.-т “Төрийн албаны болон дипломат албаны хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасны үндсэн дээр яам, ДТГ-т ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагч болон үйлчилгээ, техникийн ажилтанд энэ дүрэм нэгэн адил үйлчилнэ” гэж заасан. ТАЗ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн хүрээнд 2021.08.26-ны өдөр зохион байгуулагдсан “Ёс зүйн зөвлөлүүдийг чадавхжуулах нь” сэдэвт сургалтад тус яамны Ёс зүйн зөвлөлийн гишүүд хамрагдаж, арга зүйн зөвлөгөө мэдээлэл авав. Гадаад харилцааны яамны 2021 оны дотоод сургалтын төлөвлөгөөг 2021 оны 1 дүгээр сард батлуулан хэрэгжилтийг ханган ажиллав. Нийт 15 заалт бүхий төлөвлөгөө бөгөөд ГХЯ-ны хүний нөөцийн бодлого, албан хаагчдын давтан сурах боломжоор хангах чиглэлд онцгой анхаарч дотоодын байгууллага, аж ахуйн нэгжүүдээс мөн хөндлөнгийн сургалт, яриа, лекцүүдийг цахимаар болон танхимаар зохион байгуулж ажилласан.	100%
5	4.3.8. Монгол Улсын түүх соёлд холбогдох гадаад улсад	2. Монгол Улсын түүх, соёлд холбогдох гадаад улсад хадгалагдаж	2020 - 2024		Судалгаа хийсэн байна.	“Чингис хаан”, язгууртнуудын музей байгуулах ажлын хүрээнд Монгол Улсын түүх соёлд холбогдох гадаад улсад хадгалагдаж буй түүхийн баримт, дурсгалт зүйлсийг судлан тогтоох, эх хувь болон хуулбарлан авах ажлыг нэгдсэн удирдлагаар ханган ажиллаж	70%

	хадгалагдаж байгаа баримтыг эх нутагт нь байршуулж, үндэсний санах ой болох архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулж, архивын баримтыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	байгаа баримтыг нээн илрүүлж, худалдан авах ажлыг зохион байгуулна.				байна. Соёлын яамнаас 2020 оны 12 дугаар сард шинэчлэн ирүүлсэн “Гадаадын улс орнуудаас бүрдүүлэх, хуулбарлан авах үзмэрийн жагсаалт”-ын дагуу холбогдох ДТГ -уудтай харилцаж байна. 2020-2021 онд нийт 9 орноос 23 үзмэрийн “А” болон дижитал хуулбарыг хүлээн авч, Соёлын яам болон “Чингис хаан” музейн удирдлагад 2021 оны 6 болон 11 дүгээр сард албан ёсоор хүлээлгэн өгөв. Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхээс 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн ЗГ-1/198 дугаар албан тоотоор гадаад улсад суугаа ДТГ-ын тэргүүн нарт чиглэл хүргүүлж, “Чингис хаан” хаад, язгууртнуудын музей байгуулах Засгийн газрын шийдвэр гарсантай холбогдуулан Монголын түүх, өв соёлд холбогдох түүхийн эх сурвалж, архивын баримт, эд өлгийн зүйлсийг судлан тогтоох, тэдгээрийг эх орондоо шилжүүлэн, эсхүл хуулбарлан авах боломжийг судлан мэдээлэл ирүүлэхийг үүрэг болгосон. Ерөнхий сайдын өгсөн чиглэл болон Ажлын хэсгээс гаргасан хуулбарлан авах үзмэрүүдийн жагсаалтын мөрөөр ДТГ-ууд ажиллаж ирүүлсэн холбогдох мэдээлэл, санал, хүсэлтийг нэгтгэн Ажлын хэсэг болон Эрдэмтдийн зөвлөлд уламжилж ажилласан болно.	
6	4.3.9. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.	3. Хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газарт Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөллийг бий болгож, виз, визийн	2021 - 2024	2021 онд улсын төсвөөс 682,0 сая төгрөгөөр цахим визийн системийг нэвтрүүлсэн	Албан хаагчийг ажиллуулах орон тоо, төсөв, хөрөнгийг шийдвэрлүүлэн, мэдээллийн санг шинээр зохион байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмжийг	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хууль 2020 оны 12 дугаар сард батлагдаж, 2021 оны 6 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөж эхлээд байна. Энэ хуульд Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай байх тухай 401 дүгээр зүйлийг шинээр нэмж тусгасан. Үүний дагуу Монгол Улсын Ерөнхий сайдын 2021.03.12-ны өдрийн 63 дугаар захирамжаар Ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд ХЗДХЯ, ГХЯ, ХХЕГ, ТЕГ, ГИХГ, ДТГ-уудын дундын цахим мэдээллийн нэгдсэн сан буюу Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бий болгохоор холбогдох журмуудыг	100%

		мэдээллийн нэгдсэн санг үүсгэн, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудыг уг мэдээллийн сантай холбоно.			худалдан авч суурилуулсан байна.	боловсруулж, уг ажлыг гүйцэтгэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан. Цахим визийн системийг бүрэн нэвтрүүлсэн. Мэдээллийн нэгдсэн сангийн эхний хувилбарыг 2021.11.01-нээс туршилтын журмаар нэвтрүүлж, хөгжүүлэлтийг хийж байна. Тус сан ашиглалтад орсноор ДТГ-уудад тусгайлсан тоног төхөөрөмж шаардлагагүй бөгөөд харин програм хангамж, антивирус лиценз бүхий программыг авах бэлтгэлийг хангаж байна. Монгол Улсаас Бүгд Найрамдах Солонгос Улсад суугаа Элчин сайдын яам болон Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөх хотод суугаа Ерөнхий консулын газарт Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөллийг томилох асуудлыг Гадаад харилцааны яамны дэргэдэх Төрийн албаны салбарын зөвлөлийн хурлаар энэ оны 07 дугаар сард шийдвэрлэсэн. Тус хурлын шийдвэрийн дагуу Гадаад иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан тушаалын тодорхойлолт батлах чиглэлээр ажиллаж байна.	
7	4.5.1. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжийн хууль ёсны эрх ашгийг тууштай хамгаалж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг	1. Хилийн чанадад байгаа иргэдийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.	2021 - 2022		Иргэдийн бүртгэлийн нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлснээр үндэсний статистик мэдээний чанар дээшилж, хилийн чанадад байгаа иргэдийн төрөөс авах үйлчилгээ	Хилийн чанадад 90-ээс дээш хоног оршин суугаа иргэдийг бүртгэх программыг ГХЯ, УБЕГ, ҮСХ хамтран боловсруулж, 2018 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөс нэвтрүүлж эхэлсэн. Иргэд www.citizen.gov.mn цахим хуудсанд хандан сайн дурын үндсэн дээр бүртгүүлж байна. Өнөөдрийн байдлаар нийт 25.880 иргэн бүртгүүлээд байна. Бүртгэлийн хэсгийг ГХЯ-ны шинээр нэвтрүүлсэн цахим хуудасны http://mfa.gov.mn/overseas-missions-2 хэсэгт давхар холбон, ашиглаж байна. Ингэснээр Үндэсний дата төв, Үндэсний Статистикийн хорооны бүртгэлийн системд холбогдож байгаа болно. Дээр дурдсан бүх цахим хуудас, порталуудын аюулгүй байдал, нуцлалын	90%

	сайжруулан, цахимаар үзүүлэх үйлчилгээний тоо, төрлийг нэмэгдүүлнэ.				сайжирна. Гүйцэтгэл 40%	асуудлыг Үндэсний дата төв хариуцан ажиллаж байна. Цаашид бүртгэлийн системийг боловсронгуй болгох, Төрийн үйлчилгээний “E-Mongolia” нэгдсэн системд нэгтгэх, цахимжуулах ажлыг ГХЯ, Харилцаа Холбоо, Мэдээллийн Технологийн Газартай хамтран ажиллаж байгаа бөгөөд 2021-2022 онд бүрэн хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 4 дүгээр сард олгосон 300.000 төгрөгийн дэмжлэгийг авах хүсэлтэй, хилийн чанадад байгаа Монгол иргэдийг “E-Mongolia”, “E-barimt” порталаар дамжуулан эрхээ эдлэх боломжийг шуурхай бүрдүүлж, улмаар манай иргэд бүртгэлээ идэвхтэй хийлгэж, 2021.05.01-ний өдрийн байдлаар гадаадаас 88.857 иргэн И-баримт хаягаар шинээр бүртгэл үүсгэж, мөнгөн дэмжлэгийг өөрийн дансаар хүлээн авсан байна. 25880 иргэн citizen.gov.mn хуудаст хандан бүртгэл хийлгэсэн байна. 300,000 төгрөгийн тусламжийг 5 дугаар сард авснаас хойш Ибаримт бүртгэлийн санд гадаадаас нэмж иргэн бүртгэгдээгүй байна. Хилийн чанадад байгаа иргэдийн 16 мянга гаруй нь насанд хүрээгүй хүүхэд тул И-баримт бүртгэлд шинээр хамрагдаагүй, эцэг эхийн аль нэгийн бүртгэлд нэгтгэгдэж, мөнгөн тусламж хүлээн авсан.	
8		2. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, ААН-ийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгоно. Консулын албыг	2021 - 2024		Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. Хилийн чанадад байгаа иргэд болон ААН-үүд шаардлагатай дэмжлэг туслалцааг шуурхай авах	Гадаад харилцааны яамнаас иргэдийн эрх ашгийг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх, сайжруулах зорилгоор консулын төлөөлөл шинээр байгуулах, консулын албыг бэхжүүлэх асуудлаар хийсэн судалгаа, статистикт тулгуурлан Манжуур хотод Консулын газрыг 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдөр үйл ажиллагааг нь эхлүүлээд байна. Мөн АНУ-ын Чикаго хотод Монгол Улсын Консулын газар нээн ажиллуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганы Нэгдсэн хуралдаанаар (2021.07.06)	100%

		бэхжүүлж, бүтэц, орон тоог оновчтой хуваарилах замаар консулын төлөөлөл, үйлчилгээний хүртээмж, мэргэшсэн байдлыг сайжруулна.			боломж нэмэгдэнэ. ДТГ-т ажиллаж буй консулын ажилтнуудын чадавх сайжирч, сахилга хариуцлага өндөрсөнө.	хэлэлцэн шийдвэрлэсэн бөгөөд нээн ажиллуулах бэлтгэлийг хангаж байна. 2021 онд хилийн чанадад байгаа монгол иргэдийн эрх ашгийг хамгаалахад анхаарч ажиллав. Нэн ялангуяа цар тахлын улмаас гадаад улсад гацсан монгол иргэдийг эх оронд нь ирүүлэх, тухайн улсын эрх бүхий байгууллага, цагаачлалын албанд хандан визийн хугацааг нь сунгуулах, торгууль төлбөрөөс чөлөөлүүлэх талаар ДТГ-уудыг нэгдсэн удирдлага, чиглэлээр хангаж ажилласан. Цар тахлын хугацаанд манай иргэд, ААН-үүд цахим худалдааны залилан гэх мэт гэмт хэрэгт өртөх явдал нэмэгдсэнтэй холбогдуулан асуудлыг айлын талд уламжлан шийдвэрлүүлэх, иргэд, олон нийтэд хандан Консулын газраас сэрэмжлүүлэг нийтлэх ажлыг хэрэгжүүлэв. Цар тахлын нөхцөл байдалд түргэн шуурхай, ёс зүйтэй ажиллахыг нийт ДТГ-ууд, консулын ажилтнуудад үүрэг чиглэл болгож хяналт тавьж буйн зэрэгцээ шаардлагатай тохиолдолд УБЕГ, ЦЕГ зэрэг дотоодын байгууллагуудтай иргэдийн асуудлыг шуурхай шийдвэрлэн ажиллаж байна. Мөн БНХАУ-д залилуулсан иргэдийн асуудлаар Эрх зүйн туслалцааны гэрээний хүрээнд шийдвэрлэх талаар ХЗДХЯ, Бээжин дэх ЭСЯ-нд мэдэгдэв. ДТГ-уудын консулын үйл ажиллагааг чанаржуулах, ажилтнуудын сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх, тогтмол хяналт тавьж ажиллах тухай Гадаад харилцааны сайдаас нийт ДТГ-ын Тэргүүн нарт 2021.12.15-ны өдөр албан даалгавар хүргүүлэн, мөрдөж ажиллаж байна.	
9		3. Хилийн чанадад зорчиж буй иргэд, ААН-д нэн шаардлагатай мэдээ, мэдээлэл, зөвлөмж,	2021 - 2024		Хилийн чанадад байгаа болон түр зорчих иргэд, гадаад улстай хамтран үйл ажиллагаа	Хилийн чанадад зорчих болон “Ковид-19” цар тахлын улмаас гадаадад гацсан, эх нутагтаа ирэх хүсэлтэй иргэдэд мэдээлэл, зөвлөгөө, сэрэмжлүүлэг хүргэх үүднээс www.consul.mn цахим хуудсыг тухай бүр баяжуулж, монгол, англи хэлээр нийт 55 хэсэгт 140 гаруй мэдээ байршуулав. 2021 оны байдлаар тус	100%

		сэрэмжлүүлгийг шуурхай хүргэх, хувийн хариуцлагыг нь нэмэгдүүлэх "Хариуцлагатай аялцгаая" аяны цар хүрээг өргөжүүлж, сурталчилгаа, мэдээллийг эрчимжүүлнэ.			явуулдаг ААН-ийн хувийн хариуцлага сайжирч, гэмт хэрэг, зөрчилд холбогдох, хохирогч болох үзэгдэл 15 хувиар буурна.	цахим хуудаст 282,900 гаруй хүн хандсан. Мөн гадаад улсад зорчиж яваад нутаг буцах боломжгүй болсон иргэдийн өргөдлийг хүлээн авах, заавар, зөвлөмж өгөх хүрээнд нийт ДТГ-ын Facebook хаяг, шуурхай утсыг нээлттэй байршуулсан. Иргэдийн зорчих хөдөлгөөнийг сэргээх хүрээнд “Ковид-19”-ийн вакцинд бүрэн хамрагдсан болон PCR, IgM шинжилгээний дүн бүхий лавлагааг харилцан хүлээн зөвшөөрөх тухай БНХАУ-ын саналын дагуу 2021 оны 4 дүгээр сард дотоодын байгууллагын Ажлын хэсгийг байгуулж, вакцинд хамрагдсаныг нотлох “Олон улсын аяллын эрүүл мэндийн гэрчилгээ”-ний загварыг боловсруулсан. Иргэний овог нэр, регистрийн болон паспортын дугаар, PCR шинжилгээний хариу, вакцины нэр, тун, огноо зэрэг мэдээллийг агуулсан гэрчилгээг “E-Mongolia” цахим систем, “ТҮЦ” машинаас 3-5 минутад хэвлэн авах боломжтой болов. Гэрчилгээний загварыг дипломат шугамаар гадаад улсуудад мэдэгдэж, гэрчилгээг харилцан хүлээн зөвшөөрөх ажлыг хэрэгжүүлэв. Монгол иргэдийн олноор зорчдог БНСУ-ын талаас Инчён нисэх онгоцны буудлаар монгол иргэдийг дамжин өнгөрөхийг хориглосон шийдвэр гаргасныг цуцлуулахаар ажиллаж, 2021 оны 3 дугаар сард цуцлуулж хэвийн зорчих болов. Эх орондоо буцах хүсэлтэй иргэдээ бүрэн татан авч, 2021 оны 5 дугаар сараас эхлэн тусгай үүргийн нислэгийг ердийн нислэгт шилжүүлсэн. Хилийн хязгаарлалттай холбогдуулан иргэдийн зорчих хөдөлгөөн буурснаар гэмт хэрэг зөрчлийн тоо мөн буурсан. 2021 онд хилийн чанадад 49 иргэн гэмт хэрэг зөрчилд холбогдсон нь 2020 оноос 40,8%-иар буурсан үзүүлэлт юм.	
10		4. Хилийн чанадад байгаа иргэдэд төрийн	2021 - 2024		Төрийн үйлчилгээг иргэд түргэн	Монгол Улсын цахим визийн www.evisa.mn системийг 10 дугаар сарын 01-ний өдөр бүрэн хувилбарыг нэвтрүүлсэн. Эхний ээлжид Европын 32 улс болон	100%

		үйлчилгээг цахимаар үзүүлнэ. Үүнд: Нотариатын болон Апостиль гэрчилгээний үйлчилгээг цахимжуулах, бусад үйлчилгээний тоо, төрлийг нэмэгдүүлэх, www.consul.mn цахим хуудсыг өргөжүүлж гар утас, таблетад зориулсан хувилбар хөгжүүлнэ. Төрийн үйлчилгээний хураамжийг жигд, уян хатан, тодорхой болгох, чирэгдлийг багасгах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэн мөрдөж ажиллана.			шуурхай, хүнд сурталгүй, чирэгдэлгүй авах боломж нэмэгдэнэ.	Австрали, Шинэ Зеланд, БНСУ, БНХАУ гэсэн 36 улсын иргэнд цахим виз олгож байгаа бөгөөд цахим визийн загвар, тодорхойлолт, улсын жагсаалтыг ГХСайд, ХЗДХСайдын тушаалаар баталж, Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллага (ICAO), гадаадын улс орнуудад дипломат шугамаар хүргүүлсэн. Цахим визээр анхны гадаад зорчигч 10 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсад зорчин ирсэн бөгөөд 2021.12.30-ны өдрийн байдлаар тус системээр гадаадын 94 иргэн цахим виз мэдүүлснээс 88 иргэнд зохих журмын дагуу виз олгов. “E-mongolia” цахим хуудасны нүүр хуудаст “Гадаадад байгаа монгол иргэн” гэсэн хэсэгт шинэ цэс нэмж, 40 төрлийн үйлчилгээний холбоосыг 2021.03.19-нд байршуулав. www.consul.mn цахим хуудасны хэрэглээг өргөжүүлэн, гар утас, таблетад зориулсан хувилбарыг 2021 оны 2 сард нэвтрүүлэв. ДТГ-уудад цахим нотариатын үйлчилгээ нэвтрүүлэх тухай гэрээг ГХЯ, Монголын Нотариатчдын Танхим хооронд 2021.03.25-ны өдөр байгуулж, 16 сая төгрөгийн зардлыг Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагаас санхүүжүүлэн, програмын хөгжүүлэлт туршилтыг хийж байна. ГХЯ-наас консулын үйлчилгээ авч буй иргэдийн төлбөрийг "Гэрэгэ" киоскоор дамжуулан авч, ”Монгол шуудан”, KGB tegbe шуудан хүргэлтийн үйлчилгээг нэвтрүүлж, иргэдийн ачаалал, бөөгнөрлийг бууруулан цар тахлын халдвараас сэргийлэх ажлыг эрчимжүүлэв. Хилийн чанадад үзүүлэх консулын үйлчилгээний хураамж, үйлчилгээний хөлсний хэмжээг Засгийн газрын 195 дугаар тогтоолоор батлуулж, 2021.08.16-ны өдрөөс хүчин төгөлдөр жигд мөрдөж эхлэв.	
11		5. "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах	2021 - 2024	2021 онд 188,8 сая төгрөг иргэдэд туслах	Хилийн чанадад зайлшгүй хүнд байдалд орсон иргэдэд	2021 онд Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах санд нийт 224.0 сая төгрөг төсөвлөгдсөн боловч 2021 оны 7 дугаар сард төсвийн тодотголоор 194 сая төгрөг болгон бууруулсан. Үүнээс	100%

		сан"-гийн хөрөнгийг нэмэгдүүлж, гадаад улсад аюултай нөхцөл байдалд өртсөн иргэдэд яаралтай тусламж, дэмжлэг үзүүлнэ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, монгол иргэдийн холбогдсон, үйлдсэн гэмт хэргийг бууруулах талаар гадаад, дотоодын хууль хяналтын байгууллагуудтай мэдээлэл солилцож, хамтран ажиллана.		сангаас зарцуулсан байна.	шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлэх боломж нэмэгдэнэ. 40%	5 удаагийн хурлаар 56 өргөдөл, хүсэлтэд нийт 188,8 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн байна. 2021 онд “Ялтан шилжүүлэх тухай” гэрээний дагуу Монгол Улсын 3 иргэнийг БНХАУ-аас шилжүүлэн авсан. 2021 оны байдлаар гадаад улсад Монгол Улсын 49 иргэн гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж, 48 иргэн нас барсан байна. Үүнтэй холбогдуулан хилийн чанадад гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, мөн гадаадад нас барсан, гэмт хэрэгт холбогдсон иргэдийн ар гэрийг олж тогтоох, мэдээллийг түргэн шуурхай хүргэх ажлыг төрийн бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлж байна. Олон талт болон хоёр талт эрх зүйн туслалцааны гэрээг хүчин төгөлдөр болгох чиглэлээр идэвхтэй ажиллав. Үүнд: 1. Монгол Улс Эрүүгийн ял шийтгэлийг гадаад улсад эдлүүлэх тухай Америкийн улсууд хоорондын конвенц нь Монгол Улсын хувьд 2021.06.23-ны өдрөөс; 2. Иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, БНКУ хоорондын 1993.10.22-ны өдрийн гэрээнд өөрчлөлт оруулах тухай протокол 2021.04.20-ны өдрөөс; 3. Ханой хотноо 2018.10.16-ны өдөр гарын үсэг зурсан “Ялтан шилжүүлэх тухай Монгол Улс, БНВУ хоорондын гэрээ” 2021.05.28-ны өдрөөс; 4. Улаанбаатар хотноо 2019.07.10-ны өдөр гарын үсэг зурсан “Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс, БНВУ хоорондын гэрээ” 2021.05.28-ны өдрөөс; 5. Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засаг захиргааны онцгой бүс Макао хоорондын хэлэлцээр 2021.10.01-ний өдрөөс эхлэн тус тус хүчин төгөлдөр үйлчилж эхлэв.	
12		6. Монгол Улсын иргэдийг визийн	2021 -		Гадаад улсын визийг авах	Дипломат болон албан/сервис паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын	100%

		шаардлагаас чөлөөлөх хэлэлцээрийг гадаад улсуудтай үргэлжлүүлэн байгуулна. Зорчих болон гадаад улсын виз авах нөхцөлийг хөнгөвчлөх (цахим виз, хилийн боомтод виз мэдүүлэх, авах) чиглэлээр ажиллана.	2024		нөхцөл сайжирснаар иргэд, ААН-д тулгарч буй хүндрэл бэрхшээл багасна. (2-3 улстай хэлэлцээр байгуулна) 25%	Засгийн газар, Бүгд Найрамдах Словени Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр 2021 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байна. “Энгийн паспорт эзэмшигчдийг жуулчны визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Перу Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг хэлэлцэн дэмжсэн бөгөөд хэлэлцээрт 2021 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Бээжин хотноо гарын үсэг зурав. тус хэлэлцээр 2021.10.01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болов. Тайлангийн хугацаанд 2 визгүй зорчих хэлэлцээр хүчин төгөлдөр болов. 2021 оны байдлаар Монгол Улсын бүх төрлийн паспорттай иргэд гадаадын 25 улсад визгүй зорчиж, 32 улсад цахим визээр нэвтрэх боломжтой байна. УИХ-аас Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд 2020 оны 12 дугаар сарын 31-нд өөрчлөлт оруулан батлсан. Хуульд Монгол Улсын цахим виз, хилийн боомтод олгох виз, виз мэдүүлгийн төвийг нээх зэрэг виз олгох нөхцөлийг хөнгөвчлөх эрх зүйн зохицуулалт тусгагдсаны дагуу Ерөнхий сайдын 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 63 дугаар захирамжаар Ажлын хэсэг байгуулж, Засгийн газрын 2021.07.07-ны өдрийн хуралдаанаар 4 журмыг шинээр батлуулав. “Монгол Улсын цахим визийн систем” нэвтрүүлэх ААН-ийг сонгон шалгаруулж, ГХЯ-нд эрх олгосны дагуу гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, Монгол Улсын цахим визийн www.evisa.mn системийг 2021.10.01-ний өдрөөс амжилттай нэвтрүүлэв.	
13		7. Аялал жуулчлал, хөрөнгө оруулалтыг дэмжих ажлын хүрээнд Гадаадын	2021 - 2024		Монгол Улсын визийг гадаадын иргэд, жуулчид, хөрөнгө оруулагчид	УИХ-аас Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд 2020 оны 12 дугаар сарын 31-нд өөрчлөлт оруулан батлсан. Уг хуулиар Монгол Улсын цахим виз, хилийн боомтод олгох виз, виз мэдүүлгийн төвийг нээх зэрэг виз олгох нөхцөлийг хөнгөвчлөх эрх зүйн зохицуулалт тусгагдсан. Энэ хүрээнд Гадаадын	90%

		иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Монгол Улсын виз олгох журмыг шинэчлэн батлуулах зэргээр хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. Монгол Улсын виз олгох үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан цахим визийн систем нэвтрүүлэх, мөн виз мэдүүлгийн төвийг хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан байгуулах зэрэг шинэлэг арга хэлбэрийг бий болгоно.			хүндрэл чирэгдэлгүй авах нөхцөлийг бүрдүүлнэ. Гадаадын 1-2 оронд виз олгох төвийг хувийн хэвшилтэй хамтран байгуулсан байна. 25%	иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж гарах эрх зүйн баримт бичгүүдийн төслийг боловсруулах, цахим визийн систем нэвтрүүлэх бэлтгэлийг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 63 дугаар захирамжаар байгуулсан. Ажлын хэсэг “Монгол Улсын цахим визийн систем” нэвтрүүлэх ААН-ийг сонгон шалгаруулж, ГХЯ-нд эрх олгосны дагуу гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан, идэвхтэй хамтран ажиллаж Монгол Улсын цахим визийн www.evisa.mn системийн бүрэн хувилбарыг 2021.10.01-ний өдрөөс амжилттай нэвтрүүлэв. Уг системээр нэн тэргүүнд Европын орнууд, Австрали, Шинэ Зеланд, БНСУ, БНХАУ зэрэг 36 улсын иргэнд цахим виз олгохоор шийдвэрлэж, Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар Улсын жагсаалтыг батлан, дипломат шугамаар гадаад улсуудад мэдэгдсэн. 2021.12.30-ны өдрийн байдлаар тус системээр гадаадын 94 иргэн цахим виз мэдүүлснээс 88 иргэнд зохих журмын дагуу виз олгов. Ажлын хэсэг Засгийн газрын 2021.07.07-ны өдрийн хуралдаанаар 4 журмыг шинээр батлуулсны дотор “Монгол Улсын визийн төвийн байршлыг тогтоох, сонгон шалгаруулах, гэрээ байгуулах журам” батлагдсан бөгөөд Монгол Улсын цахим визийн системд голлох зорилтот улсууд хамрагдсаныг харгалзан, хилийн чанадад Монгол Улсын визийн төв байгуулах ажлыг түр хойшлуулсан болно. Монгол Улсын визийн төвийг ажиллуулах асуудлаар гадаадын зарим хуулийн этгээд сонирхлоо илэрхийлсэн бөгөөд Гадаад харилцааны дэд сайд Б.Мөнхжин “BLS international” ХК-ийн Бүсийн асуудал хариуцсан ерөнхий менежер Rajesh Dhutre нар 2021.03.19-ний өдөр цахим уулзалт хийж, санал солилцсон.	

14	4.5.2. Эдийн засгийн гадаад харилцаанд тэргүүлэх ач холбогдол өгч, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх, гадаад худалдаанд тулгарч байгаа хүндрэлүүдийг багасгах, хөнгөвчлөх бодлогыг үргэлжлүүлнэ.	1. Үйлдвэрлэл-худалдаа-хөрөнгө оруулалтын цогц бодлогыг дэмжихэд чиглэсэн "Төрөөс гадаад худалдааны талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг боловсруулж, батлуулна.	2021 - 2022		Гадаад худалдааны хууль, эрх зүйн орчин сайжрах боломж бүрдэнэ.	ГХ-ны сайд, ХХААХҮ-ийн сайд нарын 2020.11.25-ны өдрийн А/50, А/375 тоот хамтарсан тушаалаар Монгол Улсын Гадаад худалдааны бодлогын баримт бичиг боловсруулах үүрэг бүхий ГХ-ны сайд, ХХААХҮ-ийн сайд нарын 2020.11.25-ны өдрийн А/50, А/375 тоот хамтарсан тушаалаар Монгол Улсын Гадаад худалдааны бодлогын баримт бичиг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг ГХЯ-ны ТНБД-ын 2020.10.22-ны өдрийн А/103 тоот тушаалаар байгуулсан гадаад худалдааны хуулийн хэрэгцээ шаардлагын талаар судалгаа хийх, хуулийн төслийн үзэл баримтлал боловсруулах Ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, нийт 10 удаа хуралдав. Энэ хүрээнд эрдэмтэдийн багийг бүрдүүлж, гадаад худалдааны салбарын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, худалдааны бодлого, хэрэгжилтийн өнөөгийн байдал, эрх зүйн орчин, худалдааны бодлого, зохицуулалтын олон улсын туршлагын талаар суурь судалгааг гүйцэтгүүлэв. АХ судалгааг үндэслэн гадаад худалдааны талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулсан. АХ-ийн ахлагч бөгөөд ТҮГЭС төслийг яамны удирдлагад танилцуулав. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд УИХ-ын 2021 оны 89 дүгээр тогтоол, Засгийн газрын 314 дүгээр тогтоол, Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 55 дугаар тэмдэглэлээр хүчин төгөлдөр мөрдөж байсан төрөөс баримтлах бодлогын 200 гаруй баримт, хөтөлбөрийг хүчингүй болгосон. Ингэснээр салбарын чиглэлээр төрөөс баримтлах бодлого, үзэл баримтлал гэсэн бие даасан баримт бичиг боловсруулахгүй байхаар зохицуулсан. Иймд ЗГХЭГ-ын даргын 2021 оны 50 дугаар тушаалаар 2021-2030 он хүртэл баримтлах “Эдийн засгийн болон дэд бүтцийн хөгжлийн зорилтот хөтөлбөр”-ийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг байгуулсан бөгөөд ГХЯ-	70%

						наас төлөөлөл орж ажиллаж байна. Цаашид энэхүү заалт нь шинээр байгуулагдсан Эдийн засаг, хөгжлийн яамны эрхлэх асуудал хамаарч байгаа болно.	
15		2. "Монгол экспорт" арга хэмжээг /2019-2022/ хэрэгжүүлж дуусгана. Экспортыг дэмжих, төрөлжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортын судалгаа, маркетингийг төрөөс дэмжинэ.	2021 - 2022	Монгол экспорт хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын төсвийг батлуулахаар удаа дараа Сангийн яаманд хүргүүлсэн байна. 2021 онд төлөвлөсөн 550 сая.төгрөг батлагдаагүй байна.	"Монгол экспорт" хөтөлбөрийн 2021 оны төлөвлөгөө хэрэгжсэнээр уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт 10 хувиар нэмэгдэнэ.	Монголд үйлдвэрлэсэн экспортын бараа бүтээгдэхүүнийг ЕХ-ы иргэд, бизнес эрхлэгчдэд сурталчлах зорилго бүхий МХДТ-ийн нээлт Берлин хотноо 2021.08.07-нд болов. ЭЗ-ийг төрөлжүүлэх, нэмүү өртгийг нэмэгдүүлэх, уул уурхайн бус бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд “Монголын мэдээлэл худалдааг дэмжих төв” байгуулагдсанаар ЕХ-ны зах зээлд байгалийн цэвэр, органик түүхий эдээр үйлдвэрлэгдсэн өндөр чанартай, өрсөлдөх чадвартай бараа бүтээгдэхүүнийг сурталчлан таниулж, худалдан борлуулна. МХДТ нээгдэж буй нь монголын бараа бүтээгдэхүүн герман, улмаар ЕХ-ны зах зээлд тогтвортой орж ирэхэд бодит чухал түлхэц болно. ЗГҮАХ, МУ-г хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд тусгасан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх асуудал хариуцдаг Экспортыг дэмжих зөвлөлийн хуралдааныг зохион байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын тогтолцоог боловсронгуй болгож, “нэг цонх”-ны зарчмаар хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллав. ГХЯ-наас ХХААХҮЯ-тай хамтран Монголын ноос, ноолуурын холбооны санаачилгаар “Ноос, ноолуурын экспортыг нэмэгдүүлэх” талаар гадаадад суугаа зарим Дипломат төлөөлөгчдийн газартай санал солилцох цахим уулзалтыг 2021.05.13-ны өдөр зохион байгуулав. Түүнчлэн хурлаас гаргасан шийдвэр, илтгэх хуудас, “Монгол экспорт хөтөлбөр”-ийн II үе шатны төлөвлөгөө батлуулан ажиллав. Монгол Улсын Засгийн газрын 2021.10.13-ны өдрийн 55 дугаар	100%

						тэмдэглэлээр Монгол Экспорт хөтөлбөр хүчингүй болсон. Монгол Экспорт хөтөлбөрийн 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхтэй холбогдуулан биелэлтийг ирүүлэх чиглэлийг ХШҮДАГ-ын Е/13/21/282 дугаар цахим шуудангаар ирүүлсний дагуу ТНБД-ын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 07/5318 тоот албан бичгийг хүргүүлж, тайланг нэгтгэж байна. 2021 оны 12 дугаар сарын гаалийн статистик мэдээгээр уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт 1731,1 сая ам.долларт хүрч, нийт экспортын 18.7%-ийг эзэлж байгаа нь түүхэн дээд үзүүлэлт юм.	
16		3. Худалдаанд тулгарч байгаа хүндрэлийг багасгах зорилгоор гадаад худалдааны мэдээллийн нэгдсэн сан байгуулж, гадаад худалдаатай холбоотой бүх мэдээллийг түргэн шуурхай, нэг цэгээс авах боломжийг бүрдүүлнэ. Цаасгүй худалдаа, цахим худалдааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр	2021 - 2024		"Гадаад худалдааны мэдээллийн нэгдсэн сан" ашиглалтад орсноор хөрөнгө оруулагчид, ААН-үүд шаардлагатай мэдээ мэдээллээ хүндрэлгүй, шуурхай авах боломж бүрдэнэ.	ГХЯ, ГЕГ, Дэлхийн банкны Олон улсын санхүүгийн корпорацын дэмжлэгтэйгээр “Гадаад худалдааны мэдээллийн нэгдсэн сан” цахим хуудсыг 2020 оны 12-р сард ашиглалтад оруулж, цахим хуудсыг олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулж, тогтвортой үйл ажиллагааг хангасан. Монгол Улс “Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээр”-т нэгдэн орохтой холбогдуулан судалгаа хийх, санал дүгнэлт гаргах, хуулийн төслийн үзэл баримтлал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, хэлэлцээрт нэгдэн орсноор гарах үр ашгийн үнэлгээ хийж, хэлэлцээрийг орчуулах, холбогдох талуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг ажлыг гүйцэтгэв. Хил дамнасан цаасгүй худалдааны асуудлаарх үндэсний зөвлөлдөх уулзалтыг НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (НҮБАНДЭЗНК)-той хамтран 2019.05.02-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулж, НҮБАНДЭЗНК-оос 2019 оны 3 сард боловсруулсан бэлэн байдлын үнэлгээний тайланг хэлэлцсэн. Хэлэлцээрийг соёрхон батлах асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн төсөл, хэлэлцээрийг	100%

		ажиллана.				соёрхон батлах тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалд санал авсан. Хэлэлцээрт нэгдэн орох үйл явцыг хурдасгах зорилгоор АНДЭЗНК-ын НБДГ-аас санаачлан гаргасан “Элсэх/Соёрхон батлах үйл явцыг хурдасгах хөтөлбөр”-т хамрагдаж, холбогдох техникийн туслалцаа, зөвлөх үйлчилгээг авч байна. “Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээр” соёрхон батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг ГХ-ны сайд Б.Батцэцэг, ХЗДХ-ийн сайд Х.Нямбаатар нараар 2021 оны 5 сард батлуулав. Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг холбогдох материалын хамт ЗГХЭГ-т 2021 оны 8 дугаар сарын 31-ний өдөр 07/3758 тоотоор хүргүүлэв. Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэж, УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэв.	
17		4. Евразийн эдийн засгийн холбоотой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах үр ашгийн судалгаа хийнэ. Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээр /АПТА-2019 онд нэгдэн орсон/-ийг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангана. Хэлэлцээрийн гишүүн улс	2021 - 2024		Экспортын нэр төрөл, тоо хэмжээ нэмэгдэх, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт өсөх боломж нээгдэнэ.	Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо хооронд Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах үр ашгийг судлах Хамтарсан судалгааны ажлын хэсгийн хүрээнд нийт 7 бүлэг мэдээллийг харилцан солилцсоны үндсэн дээр хамтарсан тайлан бэлтгэхээр төлөвлөгөөнд туссан. Үүнийг хангах хүрээнд ажлын хэсгийн хурлыг цахим хэлбэрээр тогтмол зохион байгуулав. Үр дүнд 2021 онд нийт 6 бүлэг мэдээллийг харилцан солилцож, судалгааны тайлангийн төсөл ерөнхийдөө бэлэн болсон. Тайлангийн төслийг Ерөнхий сайдын ажлын алба, ГХ-ны сайдын зөвлөлийн хуралд 10 дугаар сард танилцуулж, чиглэл аван ажиллаж байна. Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах хамтарсан судалгааг 2022 оны 1 дүгээр улиралд эцэслэх бөгөөд судалгааны үр дүнд тулгуурлан хэлэлцээр байгуулах хэлэлцээнд орох эсэх шийдвэрийг 2022 оны 5 дугаар сард гаргуулна. 2020 оны 9 дүгээр сарын 29–ний өдрөөс эхлэн Ази-	70%

		орнуудад Монгол Улсын экспортын бараа бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй нөхцөлөөр нэвтрүүлэх, хөнгөлөлтийн жагсаалтад багтсан бараа бүтээгдэхүүнийг үндэсний үйлдвэрлэгчдэд сурталчлан таниулах, тухайн зах зээлд нийцүүлэн үйлдвэрлэх зэргээр зах зээлээ тэлж, экспортын барааны нэр төрлийг нэмэгдүүлнэ.				Номхон далайн худалдааны хэлэлцээрийн 7 дахь гишүүн улс болсон ба 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэлэлцээрийг хэрэгжүүлж эхлээд байна. Хөнгөлөлтийн жагсаалтад багтсан бараа бүтээгдэхүүнийг үндэсний үйлдвэрлэгчдэд сурталчлан таниулах үүднээс АНДХХ-ийн мэдээлэл, дотоодын ААН-үүдэд үүссэн боломжийн талаар богино хэмжээний видео шторкийг ТРАМ төслийн дэмжлэгтэйгээр боловсруулан ДТГ-уудад хүргүүлж, олон нийтийн сүлжээ болон томоохон мэдээллийн агентлагуудаар цацаж, ГХЯ болон ДТГ-уудын цахим хуудаст байршуулсан. Энэхүү хэлэлцээрийн бусад оролцогч талууд болох БНХАУ, БНЭУ, БНСУ, БНБАУ, БНАЛАУ, БНАСШЛУ нь худалдааг цаашид либералчлах зорилтын хүрээнд тариф, гарал үүслийн дүрэм, үйлчилгээний худалдаа, хөрөнгө оруулалт, худалдааг хөнгөвчлөх зэрэг чиглэлүүдээр дараагийн үе шатны хэлэлцээг эхлүүлээд буй бөгөөд Монгол Улс АНДХХ-ийн дараагийн үе шатны хэлэлцээнд оролцохтой холбогдуулан дээр дурдсан таван чиглэлээр хэлэлцээнд баримтлах байр суурийг боловсруулах зорилго бүхий шинжээчдийн багийг байгуулахаар ажиллаж байна.	
18	4.5.3. Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг тууштай хамгаалж, дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн	1. Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийг шинэчлэн байгуулах саналыг холбогдох улсуудад шат дараатай тавьж,	2021 - 2024		Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, зарим төрлийн үйлчилгээ, тухайлбал виз олгох зэрэг асуудлыг хөнгөвчилснөөр хөрөнгө оруулалт	Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн загвар төслийг Засгийн газрын 2019 оны 93 дугаар тогтоолоор батлсан. Уг загвар төслийг БНСУ, БНСВУ, БНЭУ болон Тайландын Хаант Улсад хүргүүлж, хөрөнгө оруулалтын хэлэлцээрийг шинэчлэн байгуулахаар хэлэлцээг эхлүүлээд байна. Түүнчлэн дээрх тогтоолын дагуу Монгол Улсаас бусад Улстай байгуулсан одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хөрөнгө оруулалтын гэрээний талаар авах арга хэмжээний төлөвлөгөөг ҮХГ-тай хамтран батлахаар төслийг гаргаж байна. Уг асуудлаар ҮХГ-тай 2021 оны	70%

	тэргүүлэх салбар, мега төслүүдэд гадаадын хөрөнгө оруулалт татах, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж авахад дэмжлэг үзүүлнэ.	хэрэгжүүлнэ.			нэмэгдсэн байна.	5 дугаар сарын 21-ний өдөр уулзалт зохион байгуулав. Түүнчлэн ҮХГ, ГХЯ болон Олон улсын санхүүгийн корпораци хамтран зохион байгуулсан "Хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомжийн шинэчлэлт" сэдэвт хэлэлцүүлэг 2021.11.30-ны өдөр зохион байгуулав. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах Ажлын хэсэгт орж ажиллав. Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн хүрээнд Төмөр замын төв коридорыг шинэчлэх хамтарсан мэдэгдэл болон ажлын төлөвлөгөөний төслийг тохиролцож, батлахад бэлэн болоод байна. Мөн тус хөтөлбөрийн хүрээнд АН3 замнал дагуух Алтанбулаг-Улаанбаатар-Замын Үүд чиглэлийн хурдны автозамын ТЭЗҮ-г олон улсын хөрөнгө оруулагчдад танилцуулж, хөрөнгө оруулалт татах чиглэлээр уулзалтуудыг хийв.	
19		2. Санхүүгийн эх үүсвэр нь шийдэгдээгүй болон шинээр хэрэгжүүлэх МЕГА төслийг сурталчлах, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, хэрэгжүүлэхэд гадаадын хөрөнгө оруулагчид, гадаад улс, олон улсын банк санхүү, хөгжлийн байгууллагатай хамтран	2021 - 2024		Улс орны хөгжлийг хурдасгах МЕГА төслүүдийг технологийн шийдэл, санхүүгийн чадавх зэргийг харгалзан шаардлага хангасан улс, компанид танилцуулснаар хөрөнгө оруулалтыг татна.	"Монгол-Оросын бизнесийг дэмжих болон хөрөнгө оруулалт татах" боломж сэдэвт уулзалтыг 2021.08.28-ны өдөр хийв. ГХЯ-наас Японы Эдийн засаг, худалдаа, үйлдвэрийн яамны дэмжлэгтэйгээр Үндэсний хөгжлийн газар, Японы Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын байгууллага /JETRO/, Олон Улсын Санхүүгийн Корпорац (IFC), Токио дахь ЭСЯ хамтран "Invest in Mongolia - Tokyo 2021" Монгол-Японы бизнес форумыг 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдөр цахимаар зохион байгуулав. Уулзалтад Японы томоохон корпорац, банк, санхүүгийн байгууллагын төлөөлөл оролцсон нь Японы бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчид Монголыг шинэ зах зээл, хөрөнгө оруулалтын шинэ талбар хэмээн үзэж байгааг илтгэв. Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Монгол дахь Америкийн Худалдааны танхим (АмЧам)-ын 2021 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн цахим уулзалтад Зочин илтгэгчээр оролцож, Монгол Улсын эдийн засаг, худалдаа, гуравдагч хөршийн бодлого, бүс	100%

		ажиллана.				нутгийн худалдаа, эдийн засгийн интеграц, хамтын ажиллагаа, Монгол-Америкийн эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүнгийн талаар мэдээлэл хийв. АмЧам Худалдааны хорооноос 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан “Олон улсын санхүүжилт”-ийн тухай дугуй ширээний уулзалтад цахимаар оролцов. Уулзалтаар АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Санхүүгийн Корпорац (DFC), АНУ-ын ЭКСИМ банкнаас томоохон төслийн хувьд хэрхэн санхүүжилт авах талаар энэхүү санхүүгийн байгууллагын төлөөлөл мэдээлэл хийж танилцуулав. Канадын Skypower global group манай улсын сэргээгдэх эрчим хүчний салбарт хөрөнгө оруулах хүсэлт гаргасныг ЭХЯ-нд танилцуулав. Монгол Улсаас АНУ болон бусад хөрөнгө оруулагч нарт танилцуулах төслийн талаар ҮХГ-тай хамтран ажиллаж, 2022 оны 3 дугаар сард АНУ-ын Вашингтон хотноо бизнес форум зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Унгарын ГХЭЗ-ийн сайд Петер Сияарто Монгол Улсад 2021 оны 7 дугаар сард ажлын аялчлал хийж, Монголд хэрэгжүүлэх хамтарсан төслүүдэд Унгарын ЭКСИМ Банк хөнгөлөлттэй зээлийн шугам нээсэн тухай мэдэгдсэн.	
20	4.5.4. Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны хүрээнд улс	1. ОХУ, БНХАУ-тай дээд, өндөр түвшний харилцан айлчлал, хамтын ажиллагааны механизмуудын уулзалтыг тогтмолжуулна.	2021 - 2024	Улсын төсвөөс 57.1 сая төгрөг зарцуулсан.	Улс төрийн харилцан итгэлцэл бэхжиж, харилцаа, хамтын ажиллагаа идэвхжиж, хамтран хэрэгжүүлж буй төсөл	ОХУ: Ерөнхийлөгч У.Хүрэлсүх ОХУ-д 2021 оны 12-р сард албан ёсны айлчлал хийв. Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.Лавровтой 2021 оны 2, 11-р сард, Ерөнхийлөгч Х.Баттулга 4-р сард, Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 7-р сард Ерөнхийлөгч В.Путинтай, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ ОХУ-ын Ерөнхий сайд М.Мишустинтэй 11-1 сард тус тус утсаар ярив. Монгол, Оросын хоорондын дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойг тохиолдуулан Б.Батцэцэг сайд 2021 оны 6-р сард ОХУ-д албан ёсны айлчлал хийж, Петербургийн олон	100%

	төр, эдийн засаг, батлан хамгаалах, худалдаа, соёл, хүмүүнлэг зэрэг бүх салбарт хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэн хөгжүүлнэ.				хөтөлбөрийн хэрэгжилтэд ахиц гарсан байна	улсын эдийн засгийн чуулга уулзалтад оролцов. ОБЕГ-ын дарга, хошууч генерал Г.Ариунбуян ОХУ-ын Онцгой байдлын яамнаас зохион байгуулсан “Иж бүрэн аюулгүй байдал 2021” олон улсын үзэсгэлэнд оролцов. Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр 2021 оны 6-р сард ОХУ-д ажлын айлчлал хийв. ОХУ-ын Засгийн газрын орлогч дарга А.Оверчук 10-р сард, Холбооны Зөвлөлийн орлогч дарга К.Косачёв 11-р сард тус тус манай улсад айлчилсан. БНХАУ: 2021 оны 4 –р сард УИХ-ын дарга Г.Занданшатар БНХАУ-ын БХАТИХ-ын Байнгын хорооны дарга Ли Жаньшутай цахимаар уулзав. Ерөнхийлөгч У.Хүрэлсүх БНХАУ-ын дарга Ши Жиньпинтэй 7–р сард утсаар ярьж, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Ли Кэчянтай 4-р сард утсаар ярьж, 10-р сард цахим уулзалт хийж, БНХАУ-ын Батлан хамгаалахын сайд Вэй Фөнхө 7-р сард Монголд, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг БНХАУ-д 7-р сард албан ёсны айлчлал хийв. Монгол, Хятадын ЗГХК-ын хоёр талын дарга нарын цахим уулзалт 9-р сард болов. Шадар сайд С.Амарсайхан БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван И-тэй 2021 оны 9-р сард ШХАБ-ын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн уулзалтад оролцох үеэрээ уулзав. Монгол, Хятадын эрдэс баялаг, эрчим хүч, дэд бүтцийн хамтын ажиллагааны зөвлөлийн III хуралдааныг 10-р сард, Монгол-Хятадын ЗГХК-ын Ажлын хэсгийн хуралдаан болон Монгол, БНХАУ-ын ГХЯ-д хоорондын Стратегийн яриа хэлэлцээний ээлжит цахим уулзалтыг 12-р сард тус тус зохион байгуулав.	
21		2. ОХУ-тай худалдааны алдагдлыг бууруулж, БНХАУ-	2021 - 2024		ОХУ-тай хийж буй экспортын хэмжээ нэмэгдэнэ.	ОХУ: Монгол, Оросын худалдааны хэмжээ 2021 оны байдлаар 2 тэрбум ам.долларт хүрч 42.2 хувиар өссөн, үүнээс импорт – 1,9 тэрбум ам доллар (+40%), экспорт –112 сая ам. доллар (+ 96.9 %) байна. ОХУ-	100%

		тай экспортын хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлнэ.			БНХАУ-тай хийж буй экспортын нэр төрөл олширч, тоо хэмжээ нэмэгдэнэ.	тай хийж буй худалдаа нь Монголын нийт худалдааны 12.8 хувьтай тэнцэж байна. Сүүлийн 3 жилийн экспортын байдал сая ам.доллараар: 2019 онд 68,0; 2020 онд 57,3; 2021 онд 112,8. Улсын эдийн засгийн стратегийн ач холбогдол бүхий газрын тосны бүтээгдэхүүнийг манай улс ОХУ-аас авч байгаа одоогийн нөхцөл байдалд худалдааны алдагдлыг бууруулах боломж хомс тул ОХУ руу экспортын хэмжээг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авч байна. Тухайлбал, ЕАЭЗХ-той чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулах судалгааны ажлыг 2022 оны 5 дугаар сард хийж дуусгах, ЕАЭЗХ-ны стандартыг судлан нэвтрүүлэх зорилгоор Монгол, Оросын Стандартчиллын байгууллага хоорондын хамтын ажиллагааг дэмжих чиглэлээр ажиллав. Цар тахлын нөхцөл байдал гадаад худалдаанд шууд сөрөг нөлөө үзүүлж байгаа ч 2021 оны байдлаар манай ОХУ руу гаргасан экспортын хэмжээ 96 хувиар өссөн нь багагүй амжилт юм. БНХАУ: Монгол, Хятадын худалдааны хэмжээ 2021 оны байдлаар 10,1 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үеэтэй харьцуулбал 37 хувиар өссөн байна. Үүнээс импорт – 2,47 тэрбум ам.доллар /Монгол Улсын импортын 41.8%/, байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 23.4 хувиар өссөн экспорт –7.63 тэрбум ам. доллар /Монгол Улсын экспортын 82.5%/ хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 28 хувиар өссөн байна. БНХАУ-д хөх тариа, улаан буудайн гурил экспортлох 13 аж ахуйн нэгжийг 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдөр БНХАУ-ын Гаалийн ерөнхий газарт бүртгэлжүүлснээр хөх тариа, улаан буудайн гурил экспортлох нөхцөл бүрдээд байна. Адууны дайвар түүхий эд болон Зөгийн балны мал эмнэлэг, хорио цээр хянан магадалгааны протоколын төслийг БНХАУ-ын ГЕГ-т хүргүүлсэн бөгөөд айлын талаас хариу хүлээж байгаа. Сүү, сүүн бүтээгдэхүүний мал эмнэлэг, хорио цээр хянан магадалгааны	

						протоколын төслийг талууд харилцан тохиролцсон бөгөөд 2022 онд байгуулахаар ажиллаж байна.	
22		3. Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын гурван талт хамтын ажиллагааг гүнзгийрүүлж, "Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг урагшлуулна.	2021 - 2024		Гурван талт хамтын ажиллагаа өргөжиж, "Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр"-ийн хэрэгжилт, төслийн явцад ахиц гарна.	“Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-т туссан “Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай ЗГ хоорондын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангах гурван талын Хамтарсан хорооны хоёрдугаар хурал 2021.05.25-ны өдөр хийв. Тус хурлаар Хамтарсан хорооны анхдугаар хурлаар тохиролцсон асуудлын хэрэгжилт, олон улсын автотээвэрлэлтэд “Ковид-19” цар тахалтай холбоотой үүсч буй хүндрэл бэрхшээлийг арилгах чиглэлээр талуудаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, 2021, 2022 онд зөвшөөрлийн бичгийг хэрэглэх зохицуулалт, Азийн авто замын сүлжээний АН-4 коридорын дагуух тээврийн маршрутыг нээж, туршилтын тээвэрлэлт хийх боломжийн талаар хэлэлцэв. “Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг урагшлуулах ажлын хэсгийн шинжээчдийн түвшний V хурлыг 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж, хурлын дүнгээр протокол байгуулахаар тохиролцов. Тус хурлаар хөтөлбөрийн хэрэгжих хугацааг дахин таван жилээр сунгах, төмөр замын төв коридорыг шинэчлэн хөгжүүлэх техник, эдийн засгийн үндэслэлийн ажлыг эхлүүлэх, “Их цайны зам” хил дамнасан аялал жуулчлалын маршрутын Замын зураглалын төслийг тохиролцох ажлыг эрчимжүүлэхээр тохиролцож, гурван улсын төрийн тэргүүн нарын ээлжит уулзалтыг зохион байгуулахад хамтран ажиллахаар тогтов. Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан ОХУ-аас БНХАУ-руу байгалийн хий нийлүүлэх хоолойг барих төслийн ажил эрчимтэй явагдаж байгаа нь гурван талын хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах нөхцөлийг үүсгэж байгаа бөгөөд энэ тал дээр монголын тал	70%

						идэвх санаачлагатай ажиллана гэдгээ илэрхийлэв. Монгол-Орос-Хятадын Аялал жуулчлалын сайд нарын VI дугаар хуралдааныг 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж хурлын дүнгээр протокол байгуулав. Тус хурлаар гурван улсын “Их цайны зам” замын зургийг эцэслэхэд эрчимтэй хамтран ажиллахаар тохиролцов.	
23		4. Монгол Улсын газар нутгаар дамжуулан ОХУ, БНХАУ-ыг холбосон байгалийн хийн хоолой барьж байгуулах төслийг хөрш хоёр оронтой хамтран хэрэгжүүлэх чиглэлээр ажиллана.	2021 - 2024		Байгалийн хий дамжуулах хоолой барих асуудлаар 3 тал зарчмын тохиролцоонд хүрэх яриа хэлэлцээнд ахиц гаргана. Төслийг хэрэгжүүлэх баримт бичгийг тохирох ажил урагшилсан байна.	Монгол Улсын газар нутгаар дамжуулан ОХУ, БНХАУ-ыг холбосон байгалийн хийн хоолой барьж байгуулах төслийн ажлыг судлах хамтарсан ажлын хэсгийн оросын талын дарга "Газпром" НХН-ийн Удирдах зөвлөлийн орлогч дарга В.А.Маркелов 2021 оны 3-р сард Монгол Улсад ирж, хийн хоолойн маршрутын талаар урьдчилсан тандалт хийв. ТЭЗҮ-ийн урьдчилсан судалгааны дүнгээр төсөл нь эдийн засгийн ашигтай гэж гарсныг “Газпром” компани мэдээлж, 2021.04.12-нд баталсан. ГХС Б.Батцэцэг 2021.6.1-5-нд ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын хүрээнд ОХУ-ын “Газпром” компанийн тэргүүн А.Б.Миллертэй 2021.6.2-нд Санкт-Петербург хотноо уулзаж, хийн хоолойн төслийн явцын талаар санал солилцов. Төслийн хэрэгжилтийг урагшлуулах зорилгоор Монгол, Оросын ЗГ хоорондын хэлэлцээрийн төслийг боловсруулж эхлэхээр тохиролцов. Хамтарсан ажлын багийн Монголын талын ахлагч, Шадар сайд С.Амарсайхан 2021.10.22-нд “Газпром” НХН-ийн Удирдах зөвлөлийн орлогч дарга В.А.Маркелов тэргүүтэй төлөөлөгчидтэй Улаанбаатар хотноо уулзаж, төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлын явц, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар хэлэлцлэв. Шадар сайд С.Амарсайхан “Газпром” НХН-ийн Удирдах зөвлөлийн орлогч дарга В.А.Маркелов, Удирдах зөвлөлийн орлогч дарга Е.В.Бурмистрова нартай Москва хотноо уулзаж төслийн хүрээнд цаашид авч	90%

						хэрэгжүүлэх арга хэмжээ, Монгол Улсад байгалийн хийн хэрэглээг нэвтрүүлэх чиглэлд хамтран ажиллах болон бусад асуудлаар санал солилцов. Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2021.12.15-18-нд ОХУ-д албан ёсоор айлчлах үеэр оросын талаас төслийн ТЭЗҮ-ийн төслийг эцэслэн гаргасныг мэдэгдэж, цаашдын шатны ажлуудыг хамтран гүйцэтгэх талаар ярилцсан болно. 2021.11.12-нд цахим хэлбэрээр болсон хөтөлбөрийн хэрэгжилтийг урагшлуулах шинжээчдийн түвшний V уулзалтаар талууд Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан ОХУ-аас БНХАУ руу хийн хоолой барих төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, холбогдох төрийн өмчит аж ахуй нэгжүүдэд 3 улсын ЗГ-ын зүгээс үргэлжлүүлэн дэмжлэг үзүүлэхээр тохиролцож, хуралдааны протоколд тусгав.	
24		5. "Талын зам" хөтөлбөрийг "Бүс ба Зам" санаачлагатай уялдуулах хүрээнд төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ.	2021 - 2024		"Талын зам" хөтөлбөрийг "Бүс ба Зам" санаачлагатай уялдуулах хүрээнд төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд ахиц гарсан байна.	Монгол Улсын “Хөгжлийн зам” болон БНХАУ-ын “Бүс ба Зам”-ын бүтээн байгуулалтыг урагшлуулах тухай Монгол Улсын Засгийн газар болон БНХАУ-ын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны төлөвлөгөөг Ерөнхийлөгч Х.Баттулгын БНХАУ-д хийсэн айлчлалын үеэр 2019 оны 4 дүгээр сард сарын 25-ны өдөр байгуулсан. Төлөвлөгөөний хавсралтад 2019-2020 онд хэрэгжүүлэхээр тусгасан 15 арга хэмжээнээс 2020 оны байдлаар бүрэн хэрэгжсэн 2, 50 хувиас дээш хэрэгжилттэй 8, удаашралтай 4, зогссон 1 ажил байна. “Талын зам” хөтөлбөр болон “Бүс ба зам” санаачилгын бүтээн байгуулалтыг урагшлуулах тухай Засгийн газар хоорондын төлөвлөгөөг шинэчлэн байгуулж, хэрэгжүүлэх хүрээнд Төлөвлөгөөний хэрэгжилтийг 2021 оны 4 дүгээр сарын байдлаар гаргаж хятадын талд хүргүүлээд буй. Цар тахлаас шалтгаалан уулзалт, арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажил удаашралтай байна. “Талын зам" хөтөлбөрийг "Бүс ба Зам" санаачилгатай уялдуулах хүрээнд төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ”. Цар тахлын	50%

						байдлыг харгалзан 2021 оны хоёрдугаар хагаст энэхүү ажлыг урагшлуулах боломж байхгүй байсан. БНХАУ-ын Хөгжил, шинэчлэлийн хорооноос тус төлөвлөгөөний биелэлтийг гаргах чиглэлд ажиллаж байгаа талаар ажлын түвшинд хариу өгөөд байна. Хятадын талаас мэдээлэл хүлээгдэж байна.	
25	4.5.5. Америкийн Нэгдсэн Улс, Япон, Европын Холбоо, Энэтхэг, Бүгд Найрамдах Солонгос Улс, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, бусад улстай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр	1.1. АНУ-тай Стратегийн түншлэлийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлж ажиллана. Үүнд:	2021 - 2024	Улсын төсвөөс (Вашингтон дахь ЭСЯ-наас) 260 ам.доллар зарцуулав.	Стратегийн түншлэлийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, хэрэгжүүлэх яриа хэлэлцээнд ахиц гарсан байна.	2021 оны 1 дүгээр сараас үйл ажиллагаагаа эхлүүлсэн АНУ-ын шинэ 117 дугаар Конгресст Америк, Монголын бүлэг байгуулагдсан. АНУ-ын Конгрессын гишүүд, гишүүдийн ажлын алба, холбогдох хороодын ажилтнуудад зориулан Монгол Улс, Монгол-Америкийн харилцаа, хамтын ажиллагааны талаар мэдээлэл өгөх "The Strategic Importance of Mongolia: The Upcoming Election and Future of Engagement" сэдэвт цахим арга хэмжээг Вашингтон дахь ЭСЯ-аар дамжуулан “US-Asia Institute” хүрээлэнтэй хамтран зохион байгуулав. Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Мянганы сорилтын корпорацтай 2018 оны 7 дугаар сард байгуулсан Хоёр дахь компакт гэрээ 2021 оны 3 дугаар сарын 31-нд хүчин төгөлдөр болсон. Компакт гэрээ хүчин төгөлдөр болсныг тэмдэглэх арга хэмжээг 2021 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр ГХЯ-нд зохион байгуулав. Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр байгуулах, СКАДА систем суурилуулах ажлын гэрээг 2021 оны 8 дугаар сарын 2-ны өдөр байгуулсан. Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн шав тавих ёслол 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдөр болсон. АНУ-ын Засгийн газраас манай улсын мансууруулах бодистой тэмцэх хүч чармайлтад зориулан олгох тусламжийг 2 сая ам.долларaар нэмэгдүүлэхээр болсон. Америкийн Иргэн-цэргийн хамтын ажиллагааны хүрээнд манай улсад Гамшгийн шуурхай удирдлагын төв байгуулахаар ажиллаж байгаа бөгөөд 40 гаруй барилгын инженер манай улсад хүрэлцэн ирсэн. Энэ санаачилгын хүрээнд 450 ам.долларын өртөг бүхий	100%

	идэвхтэй ажиллана.					хувийн хамгаалалтын хэрэгсэл манай талд хандивлав. АНУ-ын зүгээс КОВАКС-ын шугамаар 2021 оны 9 дүгээр сард 188,370 тун, 10 дугаар сард нэмэлт 899,730 тун “Файзер”компанийн вакциныг тусламжаар хандивласан. АНУ-ын Засаг захиргаа цар тахалтай тэмцэх манай улсын хүч чармайлтыг тууштай дэмжиж, тухайлбал, хамгаалалтын хэрэгсэл, 50 ширхэг амьсгалын аппарат, амьсгалын аппаратыг ашиглах сургалтын зориулалт бүхий 50 уушги орлуулагч зэрэг нийт 7 сая гаруй ам.долларын тусламж үзүүлэв.	
26		1.2. Дээд, өндөр түвшний харилцан айлчлал хэрэгжүүлнэ. Тухайлбал, Гадаад харилцааны сайд, УИХ-ын даргыг АНУ-д айлчлуулна. Зөвлөлдөх уулзалт зэрэг хоёр талын харилцааны механизмын арга хэмжээнүүд хэрэгжүүлнэ.	2021 - 2024	Улсын төсвөөс 22.1 сая төгрөг зарцуулав.	Харилцаа, хамтын ажиллагаа өргөжиж, эдийн засгийн агуулгаар баяжна.	ГХ-ны сайд Б.Батцэцэгээс АНУ-ын ТНБД Э.Блинкенийг Монгол Улсад айлчлахыг урьж, 2021.4.8-нд захидал илгээв. Түүнчлэн 2021.4.20-нд утсаар ярьж, Монгол, Америкийн харилцаа хамтын ажиллагааны талаар санал солилцов. АНУ-ын Орлогч ТНБД У.Шерман 2021.7.23-25-нд Монгол Улсад айлчлав. ГХ-ны дэд сайд Б.Мөнхжин Орлогч ТНБД У.Шермантай хэлэлцээ хийв. УИХ-ын дарга 2021.9.16-23-нд АНУ-д айлчилж, Конгрессын болон Засаг захиргааны гишүүдтэй хоёр талын уулзалтууд хийв. 2021 оны сүүлчээр “АНУ-ын 7 хоног” арга хэмжээний хүрээнд ГХЯ, Төрийн департамент хоорондын улс төрийн зөвлөлдөх уулзалт, Монгол-Америкийн ЗГ хоорондын Худалдаа, хөрөнгө оруулалтын хамтарсан хорооны ээлжит хуралдааныг зохион байгуулах саналыг америкийн талд тавьж ажилласан. АНУ-ын Төрийн департаментын Зүүн Ази, Номхон Далайн асуудал хариуцсан туслах ТНБД Д.Критенбринк 2021 оны 11-р сард Монголд айлчлахаар төлөвлөж байсан ч цар тахлын улмаас айлчлалыг 2022 онд зохион байгуулахаар хойшлуулж, улс төрийн зөвлөлдөх уулзалтыг мөн үеэр хийхээр болсон. АНУ-ын Цагаан ордны ҮАБЗ-ийн Солонгосын хойг, Монголын асуудал эрхэлсэн захирал А.Фаррар 2021.12.6-7-нд Монголд айлчлал хийв. АНУ-ын МСК-тай 2018 онд байгуулсан	100%

						Улаанбаатар хотын ус хангамжийг сайжруулах 350 сая ам.долларын 5 жилийн хугацаатай хэрэгжих Хоёр дахь компакт гэрээ 2021.3.31-нээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/89 тоот тушаалаар Монгол Улс, АНУ-ын ЗГ хооронд Агаарын харилцааны тухай хэлэлцээр байгуулахаар АНУ-ын талтай хэлэлцээ хийх ажлын хэсгийг байгуулсан. Иймд Монгол Улс, АНУ-ын хооронд шууд нислэг үйлдэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд Монгол Улс Олон улсын нисэхийн аюулгүй байдлын үнэлгээний аудитын үнэлгээний 1-р ангилал авах чиглэлээр ИНЕГ-аас АНУ-ын талтай 2 удаа техникийн уулзалт зохион байгуулсан. Монгол, Америкийн хооронд шууд нислэг үйлдэх хэлэлцээг эхлүүлэх асуудлаар ГХ-ны дэд сайдаас 2021.8.3-ны өдрийн 05/3252, 2021.12.24-ний өдрийн 8/5545 албан тоотыг ЗТХ-ийн дэд сайд буюу ажлын хэсгийн даргад хүргүүлэв	
27		1.3. АНУ-тай тохиролцсон Эдийн засгийн өргөтгөсөн түншлэлийн тухай замын зураглалыг хэрэгжүүлнэ	2021 - 2024		АНУ-тай хийж буй худалдааны эргэлт, хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.	АНУ-тай тохиролцсон Эдийн засгийн өргөтгөсөн түншлэлийн тухай замын зураглалыг хэрэгжүүлэх хүрээнд хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтын ашиг сонирхолд нийцсэн тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход чиглэсэн Эдийн засгийн хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулахаар тохиролцов. “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай Монгол, АНУ хоорондын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд харилцан ойлголцлыг баталгаажуулах захидлыг 2021.03.26-нд хоёр тал харилцан солилцсон. Энэхүү захидлаар Монголд мөрдөгдөх эрх зүйн актын төслийг www.legalinfo.mn цахим хуудаст байршуулж, олон нийтийн саналыг урьдчилан авах, олон нийтээс ирүүлсэн саналыг цуглуулах, үнэлэх, тэдгээрт хариу өгөх хууль санаачилагчийн үйл ажиллагаа болон батлагдсан эрх зүйн актыг нийтлэх	100%

						үйл ажиллагааг бүхэлд нь хянан зохицуулах эрхийг ХЗДХЯ-нд олгох, батлагдсан хууль тогтоомжийг дээр дурдсан цахим хуудаст заавал нийтэлдэг байхаар харилцан тохиролцож, хэлэлцээрийн хэрэгжилтийг баталгаажуулсан. ГХС Б.Батцэцэг Монгол дахь Америкийн Худалдааны танхим (АмЧам)-ын 2021.5.4-ний цахим уулзалтад зочин илтгэгчээр оролцож, Монгол Улсын эдийн засаг, худалдаа, “гуравдагч хөрш”-ийн бодлого, бүс нутгийн худалдаа, эдийн засгийн интеграц, хамтын ажиллагаа, Монгол-Америкийн эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүнгийн талаар ярьсан. АмЧам-аас 2021.6.10-нд зохион байгуулсан “Олон улсын санхүүжилт” дугуй ширээний уулзалтаар АНУ-ын Олон улсын хөгжлийн санхүүгийн корпорац (DFC), ЭКСИМ банкны төлөөлөл эдгээр байгууллагаас хэрхэн санхүүжилт авах талаар мэдээлэл хийж танилцуулсан. АНУ-ын Монгол дахь Худалдааны танхимаас 2021.6.23-25-ны өдрүүдэд “AmCham Doorknock 2021” арга хэмжээг цахимаар зохион байгуулж, монголын 11 бизнес эрхлэгчид оролцож, харилцан мэдээлэл солилцов. 2021 онд Монгол Улсаас АНУ-руу хийсэн экспорт 31.03 сая ам.доллар болж өссөн бол импорт 213.17 сая ам.доллар болж буурсан байна. АНУ-аас Монголд 661 сая ам.долларыг хөрөнгө оруулсан.	
28		1.4. АНУ-ын Конгрессоор гуравдагч хөршийн худалдааны тухай хуулийг батлуулах боломжийг эрэлхийлэх, Худалдааны	2021 - 2024	Улсын төсвөөс 289 ам.доллар зарцуулсан.	Яриа хэлэлцээ, лобби явуулснаар хуулийн төслийг дэмжигч гишүүдийн тоо хоёроор нэмэгдсэн	“Гуравдагч хөршийн худалдааг дэмжих тухай хууль”-ийн төсөл нь 2020 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн байдлаар Сенатын 15 гишүүн, Төлөөлөгчдийн танхимын 79 гишүүний дэмжлэгийг тус тус аваад байсан. АНУ-ын шинэ 117 дугаар Конгрессын нэр бүхий гишүүд “Гуравдагч хөршийн худалдааг дэмжих тухай хууль”-ийн төслийг 2021 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр дахин өргөн барьсан. Одоо зохих журмын дагуу хуулийг хэлэлцэх процесс үргэлжилнэ. АНУ-ын	100%

		хөнгөлөлтийн ерөнхий систем /General System of Preferences/ хөтөлбөрийг бүрэн ашиглах чиглэлээр ажиллана			байна.	117 дугаар Конгресст Гуравдагч хөршийн худалдааны хуулийн төслийг дэмжсэн 60 гаруй гишүүд дахин сонгогдсон болно. Энэ арга хэмжээний хүрээнд төвд 14, Вашингтон дахь ЭСЯ-ны зүгээс 10 орчим уулзалт (утсаар ярих, цахим уулзалт, зоог зэрэг) хийж, америкийн талын дэмжлэгийг нь авч ажиллав. УИХ-ын дарга Г.Занданшатар 2021 оны 9 дүгээр сарын 16-23-ны өдрүүдэд АНУ-д айлчилж, Конгрессын зарим гишүүнтэй уулзаж, Монгол, Америкийн эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, тэр дундаа “Гуравдагч хөршийн худалдааг дэмжих тухай хууль”-ийн ач холбогдлын талаар ярилцав. 2021 оны жилийн эцсийн байдлаар хуулийн төслийг дэмжигч, хамтран зохиогч гишүүдийн тоо 4-өөр нэмэгдэж зургаа болсон	
29		2. Япон Улстай харилцааны түвшинг ахиулж "Иж бүрэн стратегийн түншлэл"-ийн түвшинд хүргэнэ. Монгол, Японы Стратегийн түншлэлийн дунд хугацааны дараагийн хөтөлбөрийг шинэчлэн байгуулна.	2021 - 2022		Харилцаа, хамтын ажиллагаа шат ахиж, шинэ агуулгаар баяжиж, хамрах салбар хүрээ өргөжнө.	Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2021.07.21-25-нд Япон Улсад ажлын айлчлал хийж, Олон улсын Олимпын хороо, “Токио-2020” Олимпын наадмыг зохион байгуулах хорооны урилгаар Токиогийн зуны XXXII Олимпын наадмын нээлтийн ажиллагаанд оролцов. Энэхүү айлчлал нь манай улсын гуравдагч хөрш, Стратегийн түнш Япон Улстай хөгжүүлж буй харилцаа, хамтын ажиллагаа манай гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг болохыг нотолж, цаашдын хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлоход ач холбогдолтой болов. Монгол, Японы Стратегийн түншлэлийг 2017-2021 онуудад хөгжүүлэх Дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэж, 2022 оноос хэрэгжүүлж эхлэх дараагийн хөтөлбөрт тусгах монголын талын саналыг холбогдох яамдаас авч шинэ хөтөлбөрийн төслийг боловсруулж байна. Хөтөлбөрийг 2022 оны 1-р хагаст батлуулах чиглэлээр ажиллаж байна. Монгол, Японы хоорондд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой 2022 онд тохино. Ойн хүрээнд хоёр талын хамтын ажиллагааг бэхжүүлэх айлчлал, арга хэмжээг зохион	100%

						байгуулахаар төлөвлөж байна. Япон Улстай байгуулсан эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хэрэгжилттэй холбогдуулан цахим семинар, Монголын барааг Японд экспортлох талаар цахим хуралдаан зохион байгуулж, 7 хоногийн турш цахим үзэсгэлэнг МҮХАҮГ, хувийн хэвшил хамтран гаргав. ГХЯ-наас Японы Эдийн засаг, худалдаа, үйлдвэрийн яам, Үндэсний хөгжлийн газар, Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын байгууллага /JETRO/ хамтран “Invest in Mongolia-Tokyo 2021” Монгол-Японы бизнес форумыг 2021.05.20-нд цахимаар зохион байгуулж, уул уурхайн бус тэргүүлэх салбарын 6 төслийг японы хөрөнгө оруулагч нарт танилцуулав. Япон Улстай байгуулсан эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг хэрэгжүүлэх хүрээнд Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийг Япон Улсын Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд албан ёсоор бүртгүүлж, тус 2 лабораторийн шинжилгээний үнэлгээний дүнг японы тал шууд хүлээн зөвшөөрөхөөр болсон нь худалдаан дахь саад тотгорыг багасгах чухал ач холбогдолтой болов.	
30		3. Европын Холбоотой байгуулсан "Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр"-ийн хэрэгжилтийг хангаж ажиллана. - Европын улсуудын нийгэм, эдийн засгийн хөгжил, санхүү, техник, технологи,	2021 - 2024		- Европын Холбоо, түүний гишүүн улсуудтай харилцаа, хамтын ажиллагаа өргөжин хөгжинө. - Харилцааны тэргүүлэх чиглэл, салбарыг	ЕХ-той Ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн асуудлаарх яриа хэлэлцээг 2021.06.21, Бодлогын анхдугаар яриа хэлэлцээг 2021.03.10-нд цахимаар зохион байгуулснаар ЕХ-той яриа хэлэлцээний 2 шинэ механизмтай болов. Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээрээр газар зүйн заалтын хэлэлцээрийг байгуулна гэж тохиролцсоны дагуу ажлын хэсгийг ХЗДХ-ийн сайд, Гадаад харилцааны сайдын хамтарсан тушаалаар байгуулж, айлын талтай ажиллаж байна. ЗГ-ын 2021.06.16-ны хуралдаанаас БНЭстони Улстай эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор ЗГ-ын түвшний хамтарсан механизм байгуулахыг чиглэл болгосны	90%

		ажиллах хүчний давуу тал дээр тулгуурлан улс тус бүрээр хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлно. - Европын зарим улстай шинээр яриа хэлэлцээний механизм бүрдүүлэхийг зорино.			тодорхойлсноор эдийн засаг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаанд ахиц гарна. - ЗГХК, Гадаад харилцааны яам хоорондын Зөвлөлдөх уулзалтын механизм байгуулсанаар хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж авах боломж нэмэгдэнэ.	дагуу Монгол, Эстонийн ГХЯ хоорондын II зөвлөлдөх уулзалтын үеэр (2021.07.09) ЗГХК байгуулах саналыг эстонийн талд тавив. ИБУИНХУ ЕХ-ноос гарсантай холбогдуулан Британийн худалдааны хөнгөлөлтийн ерөнхий систем болох “Сайжруулсан нөхцөл”-д Монгол Улс 2021.01.01-нээс хамрагдсанаар ЕХ-ны Хөнгөлөлтийн ерөнхий систем (GSP+)-тэй ижил тарифын хөнгөлөлт эдлэх болов. Монгол, Италийн ЗГХХК-ын III хуралдаан, ГХЯ хоорондын улс төрийн III зөвлөлдөх уулзалтыг 2021.06.22-нд цахимаар зохион байгуулав. Монгол, Австрийн ЗГ хооронд 2019 онд байгуулсан Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд эрүүл мэнд, дэд бүтцийн салбарт нийт 40 сая еврогийн өртөг бүхий төслүүд хэрэгжүүлэхээр айлын талтай тохиров. Польш Улсын ЭСЯ-аа 2021.01.15-нд албан ёсоор дахин нээхээр шийдвэрлэж, Элчин сайд К.Бойко 3 дугаар сард хүрэлцэн ирэв. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын 50 сая еврогийн нөхцөлт зээлийн хэлэлцээрийг сунгах нэмэлт хэлэлцээр 2021.05.21-ний өдрөөс хүчинтэй болов. Унгар Улсын Гадаад хэрэг, худалдааны сайд П.Сияярто 2021.07.21-нд Монгол Улсад айлчилж, Унгарын Засгийн газраас олгож буй 33 ширхэг амьсгалын аппаратыг хүлээлгэн өгөв.	
31		5. БНСУ-тай харилцаагаа өргөжүүлж, "Стратегийн түншлэл"-ийн түвшинд хүргэнэ.	2021 - 2023	Улсын төсвөөс 0.8 сая төгрөг зарцуулсан.	Хоёр орны харилцаа хамтын ажиллагаа шинэ шатанд гарч, эдийн засгийн агуулгаар баяжина.	Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Бүгд Найрамдах Солонгос Улсын Ерөнхийлөгч Мүн Жэ Ин-тэй 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр хийсэн дээд түвшний цахим уулзалтаар хоёр улсын төрийн тэргүүн нар Монгол Улс, БНСУ-ын “Иж бүрэн түншлэл”-ийн харилцааг шат ахиулан “Стратегийн түншлэл”-ийн түвшинд хүргэж, энэ тухай Хамтарсан тунхаглал гаргав. Монгол Улсын Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, БНСУ-аас Монгол Улсад суугаа бүрэн эрхт Элчин сайд Ли Ё Хун нар 2021 оны 12 дугаар	100%

						сарын 27-нд 10 аймагт хэрэгжүүлэх төслийн багц 1 (Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай) 52,378 ам.доллар, багц 3 (Говьсүмбэр, Сүхбаатар, Хэнтий) 33,642 ам.доллар зэрэг 7 аймгийн төвд хэрэгжих төслийн барилга угсралтын ажлыг эхлүүлэхээр гэрээнд гарын үсэг зурсан. Төсөлд хамрагдах 10 аймгаас үлдсэн 3 аймгийн төв (Архангай, Дундговь, Төв)-ийн дулааны станц байгуулах төслийг 2022 онд эхлүүлэх талаар анхаарч ажиллана. Монгол Улсын Барилга, хот байгуулалтын яамны “Барилга хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар БНСУ-ын Инчоны эдийн засгийн чөлөөт бүсийн захиргаа хооронд 2021 оны 12 дугаар сарын 21-нд хамтын ажиллагааны Санамж бичиг байгуулав. “Чингис хаан” олон улсын нисэх буудлыг түшиглэн “Хөшигийн хөндий”-д шинэ дагуул хотыг байгуулахад БНСУ-ын Инчоны эдийн засгийн чөлөөт бүсийн туршлагыг судалж, хот төлөвлөлт, технологи, арга зүйн дэмжлэг авч, хамтран ажиллах нөхцөл бүрдэв.	
32		6. Бүгд Найрамдах Турк Улстай худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр тус улсаас хөнгөлөлттэй зээл, тусламж авахыг зорино.	2021 - 2024		Хоёр орны харилцаа хамтын ажиллагаа өргөжиж, худалдаа өснө.	Монгол Улсын Шадар сайдын БНТУ-д 2020 оны 2-р сард хийсэн айлчлалын мөрөөр Чөлөөт бүсийн салбарт хамтран ажиллах тухай байгууллага хоорондын Санамж бичигт 2021 оны 1-р сард гарын үсэг зурав. 2018 онд байгуулсан Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр 2021.03.01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн нь Турк Улсад ажиллаж амьдарч буй 5000 орчим иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалахад чухал ач холбогдолтой болов. Эдийн засаг, худалдааны Монгол, Туркийн Засгийн газар хоорондын хамтарсан хорооны IX хуралдааныг 2021.11.15-16-ны өдрүүдэд Анкара хотноо зохион байгуулав. Хуралдаанаар хамтын ажиллагааны 24 чиглэлийн асуудлыг хэлэлцэн тохирч, протокол	100%

						үйлдэв. Тухайлбал, Худалдааны ажлын хороо болон Хөдөө аж ахуйн хамтарсан ажлын хэсэг байгуулах, Хөрөнгө оруулалтыг харилцан дэмжих, хамгаалах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг шинэчлэх, бизнес форум зохион байгуулах, малын гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх зорилгоор хорио цээр, эрүүл ахуйн нөхцөлийг тохирохоор болов. “Нэг тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хамтран ажиллах, агаарын тээврийн үйлчилгээг сайжруулах зорилгоор зөвлөлдөх уулзалт хийх, аялал жуулчлал, залуус, спорт, эрүүл мэндийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрүүд байгуулах, Орхоны хөндийд аялал жуулчлалын цогцолбор байгуулах төсөлд хамтран ажиллахаар тохиров. Хоёр улсын худалдааны эргэлт 2020 онд 39.84 сая ам.доллар, үүнээс экспорт 2.51 сая ам.доллар, импорт 37.33 сая ам.доллар байв. 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр Турк Улстай нийт 60.5 сая ам.долларын худалдаа хийснээс экспорт 2.8 сая ам.доллар, импорт 71.2 сая ам.доллар байна. Туркээс 1990-2021 онд нийт 22.5 сая ам.долларын хөрөнгө оруулалт, 82 компани бүртгэгдсэн. Хөрөнгө оруулалтын 60 хувь худалдаа, нийтийн хоолны салбар, 13.2 хувь хөдөө аж ахуй, 6.3 хувь хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 3.8 хувь аялал жуулчлал, 3.6 хувь тээвэр, 2.1 хувь барилга, 1.4 хувь соёл урлаг, боловсролын салбарт тус тус ногдож байна.	
33		7. Зүүн өмнөд болон Төв Азийн бүс нутгийн орнуудтай харилцаагаа гүнзгийрүүлж, эдийн засгийн интеграцад орох	2021 - 2024		Тус бүс нутагт гаргах экспортын бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ нэмэгдэж, гадаад	2021 оны байдлаар манай улс Зүүн Өмнөд Азийн 9 улстай худалдаа хийсэн ба худалдааны эргэлт 157.6 сая ам.долларт хүрсэн нь КОВИД-19 цар тахлын үед хэдий ч худалдаа, эдийн засгийн харилцаа өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад харьцангуй тогтвортой байна. Бүс нутаг руу хийх экспортыг нэмэгдүүлэх, АСЕАН-ы орнуудтай хоёр талын эдийн засаг, худалдаа хөрөнгө оруулалт, бизнес эрхлэгч	70%

		боломжийг эрэлхийлэх, харилцан ашиг сонирхлыг бий болгоно. -Уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг дэмжиж, нэр төрлийг нэмэгдүүлэх, хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлээр дамжуулан Азийн болон "гуравдагч" бусад зах зээлд Монголын бараа бүтээгдэхүүнийг гаргах, бизнес эрхлэгчид шинэ зах зээлд нэвтрэхэд нь бодит дэмжлэг үзүүлнэ.			худалдаа, хөрөнгө оруулалт өсөх боломж бүрдэнэ.	хоорондын харилцааг өргөжүүлэн нэмэгдүүлэх чиглэлд идэвхтэй ажиллаж байна. Ялангуяа хүнс, хөдөө аж ахуйн салбарт тус бүс нутгийн улс орнуудаас хөрөнгө оруулалт татах замаар хамтарсан үйлдвэр байгуулах, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ гуравдагч зах зээлд гаргах, АСЕАН-ы стандарт, чанарын баталгаажилтын стандартуудыг нэвтрүүлэх замаар тус бүс нутагт чиглэсэн экспортыг нэмэгдүүлэх бодит боломж байгаа тухай бизнес эрхлэгч нарт мэдээллээр хангах чиглэлээр ажиллаж байна. Ерөнхийлөгч У.Хүрэлсүх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 76 дугаар чуулганы Ерөнхий санал шүүмжлэлд оролцох үеэрээ 9 дүгээр сарын 22-ны өдөр Вьетнам Улсын Ерөнхийлөгч Нгуен Суан Фук-тай уулзаж Монгол, Вьетнамын хамтын ажиллагааг цаашид бүхий л салбарт эрчимжүүлэн хөгжүүлэх, худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тээврийн нөхцөлийг сайжруулах болон хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, уул уурхай, аж үйлдвэрийн салбарт хамтран ажиллах боломжийн талаар санал солилцов. Энэтхэг Улсад коксжих нүүрс экспортлох асуудлаар хоёр Засгийн газрын холбогдох байгууллагууд хамтран ажиллаж эхлээд байна. Төв Азийн бүс нутгийн орнуудтай хийсэн худалдааны хувьд КОВИД-19 цар тахлын улмаас тээвэр, ложистикийн саад бэрхшээл гарсантай холбогдуулан худалдааны хэмжээ нэмэгдээгүй, буурсан үзүүлэлттэй байна. Монгол, Казахстаны Засгийн газар хоорондын комиссын ээлжит VIII хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр талууд ажиллаж байна. Мөн Казахстан Улсад өндөр хэмжээнд айлчлал зохион байгуулж энэ үеэр хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх талаар санал солилцохоор төлөвлөж байна.	

34		8. Франц Улстай харилцааг Иж бүрэн түншлэлийн түвшинд хүргэх замын зураглалыг баталж, хэрэгжүүлнэ.	2021 - 2024		Хоёр улсын харилцаа хамтын ажиллагаа шинэ шатанд гарч, эдийн засгийн агуулгаар баяжна.	Замын зураглалын төсөл боловсруулж, францын талд хүргүүлсний дагуу францын тал саналаа 2019 оны 10-р сард ирүүлсэн. Замын зураглалын төсөлд 2021 оны 5-р сард холбогдох яамд, байгууллагуудаас дахин санал авч шинэчилсэн. Шинэчилсэн төслийг 2021.06.18-нд Парис дахь ЭСЯ-нд хүргүүлж, францын талд гардуулахыг чиглэл болгосон. Засгийн газрын түвшинд францын талтай хамтран дараах төслүүдийг хэрэгжүүлж байна. 1. Агаараас аврах ажиллагаа явуулах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төслийн санхүүгийн хэлэлцээрийг 2019.10.16-нд байгуулсан. Төслийн хүрээнд ЕС-145 маркын 4 нисдэг тэрэг авахаас 3, гал унтраах тусгай автомашин 42-г хүлээн авахаас 21 автомашин тус тус хүлээн авсан. Ангар, сургалтын байгууламж барих явц-барилгын цутгалт хийгдсэн, барилгын угсралт явцдаа байна. 2. Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслийн санхүүгийн хэлэлцээрийг 2020.5.12-нд байгуулсан. Сангийн яам төслийн нэгдүгээр шатны зардлын урьдчилгаа болох 6.7 сая еврог 2020.9.21-нд айлын талд шилжүүлсэн. Төслийн хүрээнд дүүжин тээврийг 2 шугам барихаар төлөвлөсөн. 1-р шугам: Баянхошууны эцэс – Ханын материал – 3,4-р хороллын эцэс (4.9 км) – ТЭЗҮ хийгдсэн. 2-р шугам: тодорхойгүй. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар 1-р чиглэлийг өөрчлөх саналтайгаа Францын Элчин сайд Ф.Мэрлинд 2021 оны 7 дугаар сард илэрхийлсэн. Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төслийн санхүүгийн хэлэлцээрийн гэрээний эрх 2020.9.1-нд нээгдэж, 2023.9.1-ний дотор зээлийн хөрөнгийг ашиглаж дууссан байна гэж заасан. Монгол Улсын Засгийн газрын 2021.08.31, 2021.11.17-ны өдрийн хуралдаанаар энэхүү төслийн асуудлыг хэлэлцсэн	70%

						бөгөөд төслийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор төслийн ТЭЗҮ-ийг төслийн үндсэн хөрөнгөөр шийдвэрлэх талаар францын талтай зөвшилцөх үүргийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгасан.	
35		9. Канад Улстай явуулж буй хамтын ажиллагааг Иж бүрэн түншлэлийн түвшинд хүргэхийг зорьж ажиллана. Канад Улстай хоёр талын хамтын ажиллагааны замын зураглалыг байгуулж, худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хүнс, хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.	2021 - 2024		Харилцаа, хамтын ажиллагаа өргөжин хөгжиж, хамрах салбар хүрээ нэмэгдэнэ. Худалдаа, хөрөнгө оруулалт өснө.	Монгол, Канадын Засгийн газар хоорондын Дугуй ширээний уулзалтын IX хуралдааныг 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулж, энэ үеэр талууд “Иж бүрэн түншлэлийн төлөөх Монгол, Канадын хамтын ажиллагааны Замын зураглал”-ыг тохиролцов. Хоёр улс хоорондын худалдаа, бизнесийг нэмэгдүүлэх зорилгоор Худалдаа, аж үйлдвэрийн танхимуудын хооронд харилцаа тогтоох, бизнес форум зохион байгуулах ажилд өндөр ач холбогдол өгч, Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн форум зохион байгуулахаар Дугуй ширээний уулзалтаар мөн тохиролцсон. Монгол-Канадын Хүнс, хөдөө аж ахуйн яамд хооронд байгуулсан 2010 оны Санамж бичгийн дагуу хоёр яамны Хамтарсан хорооны III хурлыг 11 дүгээр сарын 30-ны өдөр Оттава хотноо зохион байгуулсан. Монгол, Канадын Хөдөө аж ахуйн хамтарсан хорооны III хурал 2021 оны 11 дүгээр сарын 30-ний өдөр Оттава хотод зохион байгуулав. Монголын төлөөлөгчдийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд Г.Батсуурь Канадын талын төлөөлөгчдийг Хөдөө аж ахуй, хүнсний туслах Дэд сайдын үүргийг түр орлон гүйцэтгэгч Катлиин Донохью нар тэргүүлж оролцов. Хоёр тал хамтын ажиллагааг Иж бүрэн түншлэлд хүрэх Замын зураглалын хүрээнд газар тариалан, мал аж ахуйн хамтын ажиллагааны боломжийн талаар дэлэгрэнгүй санал солилцов. Хөдөө аж ахуйн хамтарсан хорооны уулзалтын хүрээнд Дэд сайд	100%

						Г.Батсуурь тэргүүтэй төлөөлөгчид Канадын Саскатчеван мужийн Хөдөө аж ахуйн 50 жилийн ойн үзэсгэлэн Агрибишн арга хэмжээнд оролцож, мужийн Хөдөө аж ахуйн туслах Дэд сайд Денни Маккол, Худалдаа, түншлэлийн байгууллагын ерөнхийлөгч Крис Деккер, Мал, тэжээлийн судалгааны хүрээлэнгийн захирал Скот Райт нартай уулзаж хамтын ажиллагааны талаар санал солилцсон нь үр дүнтэй болов. 2021 оны урьдчилсан мэдээгээр Монгол Улсаас Канадад 759.9 сая ам.долларын бараа экспортолж, 24.2 сая ам.долларын бараа импортолж, нийт худалдааны эргэлт 784.1 сая ам.доллар байна.	
36		10. Ойрх Дорнод, түүний дотор Булангийн орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлж, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2021 - 2024	“Экспо 2020 Дубай” арга хэмжээнд оролцох зардалд улсын төсвөөс 219,9 сая төгрөг, ГХЯ-ны томилолтын зардлаас 75.8 сая төгрөгийг тус тус зарцуулаад байна.	Ойрх Дорнодын орнуудтай эдийн засгийн харилцаа өргөжинө. Буцалтгүй тусламжаар тодорхой төсөл хөтөлбөр хэрэгжих боломж нээгдэнэ.	АНЭУ-ын ЗГ-ын 2 сая ам.долларын буцалтгүй тусламжаар Хэнтий, Дорноговь аймгийн төв, Нийслэлийн Сүхбаатар дүүрэгт тус бүр 1 цэцэрлэг шинээр баригдав. Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2021.03.03-ны ЗГ-ын хуралдаанаар Кувейтийн сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр баригдаж буй “Түлэнхийн төв”-ийн барилгын ажлыг хурдасгаж энэ оны II улиралд багтаан ашиглалтад оруулахыг даалгасан. 2021 оны 9 дүгээр сарын байдлаар төслийн гүйцэтгэлийн ажил 97 хувьтай байна хэмээн ЭМЯ-наас мэдэгдсэн. 2021 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр Кувейтийн сан, Монгол Улсын СЯ, ЭМЯ, ЗТХЯ, ГХЯ-ны төлөөллийн уулзалтыг цахим хэлбэрээр зохион байгуулав. Уулзалтын үеэр тус сангийн санхүүжилтээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн явцын талаар мэдээлэл солилцож, төслүүдийг хэрэгжүүлж дуусгах хугацааг 2022 оны 12 дугаар сарын 31 хүртэл сунгахаар тохиролцов. Хэнтий аймагт “Өндөрхаан нисэх онгоцны буудлыг шинэчлэн барих төсөл”-ийн ажлыг Багц-I барилга, Багц-II аэродром гэсэн 2 тендер болгон зарласан. Багц-2 аэродромын гэрээний дагуух ажил 55.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Катар Улсын Засгийн газраас 10	100%

						сая ам.долларын 0 хувийн хүүтэй олгох зээлийг буцалтгүй тусламж болгуулахаар ажилласан. Катарын хөгжлийн сангийн зүгээс асуудлыг бүх талаар судалж үзээд Монголд холбогдох зээлийг буцалтгүй тусламж хэлбэрээр олгох боломжгүй гэдгээ мэдэгдээд байна. Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг 2021 оны 11 дүгээр сарын 8-11-ний өдрүүдэд Катар Улсад айлчлал хийх үеэрээ Катар Улсын Ерөнхий сайд, Гадаад хэргийн сайд, Катарын сангийн Ерөнхий захидал зэрэг албан тушаалтнуудтай уулзаж, цэцэрлэгийн барилгын санхүүжилтийн асуудлаар ярилцав. Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг 2021 оны 11 дүгээр сарын 14-17-ны өдрүүдэд АНЭУ-д айлчилж, “Экспо 2020 Дубай” дэлхийн үзэсгэлэнд оролцов. “Экспо 2020 Дубай” дэлхийн үзэсгэлэнгийн хүрээнд 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Монгол-АНЭУ-ын бизнес форум зохион байгуулагдав. Бизнес форумд Монгол, АНЭУ-ын 70 гаруй компанийн төлөөлөгчид оролцож, хамтын ажиллагааны талаар мэдээлэл солилцов.	
37		11. Латин Америкийн орнуудтай: Аргентин Улстай байгуулсан Техникийн хамтын ажиллагааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ.Чили, Колумби зэрэг улстай уул уурхай, ХАА-н	2021 - 2024		ХАА, уул уурхайн салбарын харилцаа, хамтын ажиллагаа өргөжиж, туршлага хуримтлуулна. Эдийн засгийн харилцаанд ахиц гарна.	Аргентин: Хоёр улсын ГХЯ-д хоорондын 2021.12.09-нд болсон III зөвлөлдөх уулзалтаар Аргентинтай байгуулсан Техникийн хамтын ажиллагааны тухай ЗГ хоорондын хэлэлцээрийн хүрээнд хөтөлбөрүүд хэрэгжүүлэх асуудлаар санал солилцож, хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах үүднээс Хамтарсан ажлын хэсэг байгуулж, ХАА-н яамд хооронд цахим уулзалт зохион байгуулахаар тохиролцсон. Чили: Хоёр улсын Уул уурхайн яамд хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт Чилиэс Монголд хавсран суугаа Элчин сайд Улаанбаатарт ирж ажиллах үеэрээ гарын үсэг зурахаар төлөвлөсөн боловч айлчлал цар тахлын улмаас хойшлогдсон. Чилийн талаас цар тахлын нөхцөл байдал намжмагц Санамж бичигт гарын үсэг зурахаа илэрхийлсэн. 2021.05.27-нд зохион байгуулсан Монгол, Чилийн анхдугаар бизнес	90%

		салбарт харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлнэ.				уулзалтад уул уурхай, ХАА, хүнс, жимсний чиглэлийн компани, мэргэжлийн холбоод оролцож, туршлага хуваалцсан. Колумби: Техникийн хамтын ажиллагааны тухай Монгол, Колумбийн ЗГ хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг манай талаас эцэслэж, дотоодын процедур эхлүүлсэн тухайгаа колумбийн талд 2021.03.24-нд мэдэгдсэн. Колумбийн талаас хариу авах чиглэлээр Хавана дахь ЭСЯ-наас улирал тутам ноот бичиг хүргүүлж, Элчин сайд уулзалт хийсэн боловч Колумбид үүсээд буй улс төр, нийгмийн тогтворгүй байдал, ГХЯ-ны удирдлага солигдсон зэрэг шалтгаанаар тодорхой хариу ирүүлээгүй, хэрэгжилт удаашралтай байна. Куба: Хоёр улсын ХАА-н яамд хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулахаар 2021 оны 4-р сард төсөл солилцож, монголын талаас хариу хүлээгдэж буй. Асуудлыг урагшлуулах хүрээнд Латин Америкийн улсуудын ХАА-н салбарын тухай танилцуулгыг ХХААХҮЯ-нд 2021.09.08-нд хүргүүлсэн. Монгол, Кубын ГХЯ-д хоорондын 2021.12.15-нд болсон IV зөвлөлдөх уулзалтаар ХАА-н хамтын ажиллагааны асуудлыг хөндөж ярилцсан. МҮХАҮТ, Кубын Худалдааны танхим хооронд 2021.03.12-нд Хамтын ажиллагааны гэрээ байгуулах, мөн 2021.05.13-нд Монгол, Кубын эрүүл мэнд, биотехнологийн салбарын анхдугаар бизнес уулзалт зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллав.	
38	4.5.6. Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний системийн байгууллагууд, олон улсын болон бүс	1. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулган, Ази, Номхон далайн эдийн засаг нийгмийн комиссын чуулган	2021 - 2024	Улсын төсвөөс 0.4 сая төгрөг төгрөг зарцуулсан.	Хурал, арга хэмжээнд төлөөлөгчдийн үр дүнтэй, идэвхтэй оролцоог хангаж, улсынхаа эрх	Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2021.9.19-23-ны өдрүүдэд Нью-Йорк хотноо ажиллаж, НҮБ-ын ЕА-н 76-р чуулганы Ерөнхий санал шүүмжлэлд 2021.9.22-ны өдөр дэлхий дахины энх тайван, аюулгүй байдал, тогтвортой хөгжил, сайн засаглал, эдийн засаг, нийгэм, эрүүл мэнд, КОВИД-19 цар тахлын хор уршиг, түүнийг даван туулах талаарх Монгол Улсын байр суурийг илэрхийлж, үг хэлсэн. ГХС чуулганы үеэр	100%

	нутгийн түвшинд хамтын ажиллагааг идэвхтэй үргэлжлүүлж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	болон Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Сайд нарын зөвлөлийн уулзалт, АСЕМ-ын Дээд түвшний уулзалт, Гадаад хэргийн сайд нарын уулзалт зэрэг НҮБ, түүний системийн байгууллагууд, олон улсын болон бүс нутгийн байгууллагаас зохион байгуулах хурал, арга хэмжээнд төлөөлөгчдийн үр дүнтэй, идэвхтэй оролцоог хангаснаар өөрийн улсын эрх ашгаа хамгаалж, олон улсад нэр хүндээ улам бататгана.			ашгийг хамгаалж, олон улсад нэр хүндээ бэхжүүлнэ.	болсон Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Сайд нарын уулзалт, Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Сайд нарын уулзалтад оролцож, үг хэлсэн. Ерөнхийлөгч Х.Баттулга 2021.4.26-27-нд цахим хэлбэрээр болсон НҮБ-ын Ази, Номхон Далайн эдийн засаг, нийгмийн комиссын 77-р чуулганы нээлтэд мэндчилгээ дэвшүүлэв. ГХС Б.Батцэцэг чуулганы 2 дахь өдрийн хуралдаанд цахимаар оролцож, “Ази, Номхон далайн бүс нутгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх замаар хямралыг даван туулах нь” сэдвээр байр сууриа илэрхийлж, үг хэлэв. Монгол Улсаас НҮБ-ын АНДЭЗНК-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч А.Төмөр Комиссын 77-р чуулганы дэд даргаар ажиллав. Ерөнхийлөгч Х.Баттулга 2021.5.30-31-нд цахимаар болсон “Ногоон өсөлт ба Дэлхийн зорилт-2030 хөтөлбөрийн төлөөх түншлэлийн Сөүлийн дээд хэмжээний уулзалт”-д мэндчилгээ дэвшүүлэв. Ерөнхийлөгч У.Хүрэлсүх ИБУИНХУ-ын Глазгоу хотноо 2021.11.1-2-нд болсон Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн удирдагчдын дээд түвшний уулзалтад оролцож, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх талаарх манай байр суурийг илэрхийлэв. УИХ-ын дарга Г.Занданшатар 2021.9.6-8-нд Вена хотноо болсон Парламентын дарга нарын дэлхийн 5-р Бага хурлын Ерөнхий хэлэлцүүлэг, салбар хуралдаануудад оролцож, үг хэлэв. Ардчиллыг хамгаалах нөхдийн бүлэг, Стокхолм хотноо төвтэй Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн хамтран “Хуурамч мэдээллээс ардчиллаа хамгаалах нь” сэдвээр цахим хэлэлцүүлгийг 2021.5.6-нд зохион байгуулав. Энэ 2021 оны 7-р сард болсон Тогтвортой хөгжлийн асуудлаарх улс төрийн өндөр түвшний чуулга уулзалтад ҮХГ-ын дэд дарга Б.Булганчимэг тэргүүтэй төлөөлөгчид оролцоход дэмжлэг үзүүлэв.	

39		2. Зүүн хойд Азийн аюулгүй байдлын асуудлаарх Улаанбаатарын яриа хэлэлцээ зэрэг олон улсын бага хурал, олон улсын болон бүс нутгийн байгууллагатай хамтран хурал, арга хэмжээг Монгол Улсад зохион байгуулж бүс нутгийн түвшинд байр сууриа бэхжүүлнэ.	2021 - 2024		Олон улсын хурал дотооддоо зохион байгуулснаар нэр хүнд өсч, гадаад улсад байр суурь бэхжиж цаашлаад аюулгүй байдал хангагдсан байна	Манай улс Зүүн хойд Азийн бүс нутагт яриа хэлэлцээний механизмыг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор 2014 оноос эхлэн “Улаанбаатарын яриа хэлэлцээ” олон улсын бага хурлыг тогтмол зохион байгуулж ирсэн боловч цар тахлын улмаас тус хурлыг энэ онд (2020 онд мөн хийгээгүй) зохион байгуулах боломжгүй болсныг болон Гадаад харилцааны яамны удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу ээлжит “Улаанбаатарын яриа хэлэлцээ” олон улсын бага хурлыг 2022 оны 6 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд зохион байгуулахаар тогтсоныг е/06/21/1624 тоот цахим шуудангаар нийт ДТГ, ГХЯ-ны бүх газруудад мэдэгдэв. Тус цахим шуудангаар олон улсын бага хурлын танилцуулга, 7 дугаар хурлын урьдчилсан хөтөлбөрийг англи, монгол хэлээр бэлтгэн хүргүүлэв. “Улаанбаатарын яриа хэлэлцээ” олон улсын 7 дугаар бага хурлын бэлтгэлийг хангах хүрээнд 2021 оны 9 дүгээр сараас эхлэн ССХ-тэй ажлын хэргийн түвшинд тогтмол уулзалт хийж, 11 дүгээр сард ГХЯ-ны ОТХАГ-ын захирал Д.Гэрэлмаа тус хүрээлэнгийн захирал М.Даваадоржтой уулзах үеэр бэлтгэл ажлын хамтарсан төлөвлөгөө гаргах шийдвэрт хүрч, 12 дугаар сард ССХ-нд төлөвлөгөөний төсөл хүргүүлэв.	70%
40		3. "Монгол Улсад НҮБ-аас үзүүлэх хөгжлийн тусламжийн хүрээ" хөтөлбөр, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн сантай хэрэгжүүлж буй Орны хөтөлбөр зэрэг баримт	2021 - 2024		Хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тайлангийн хурлыг зохион байгуулж, хөтөлбөрийн оны тайланг хэлэлцэж, ололт амжилт, сорилт сургамж болон цаашид	НҮБ-аас Монгол Улсад 2017-2022 онд үзүүлэх хөгжлийн тусламжийн хүрээ” баримт бичгийн 2020 оны хэрэгжилтийг хянан хэлэлцэх Засгийн газар болон НҮБ-ын Хамтарсан удирдах хорооны хурлыг 3 дугаар сард цахимаар зохион байгуулж, НҮБ-аас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн 2020 оны тайланг хэлэлцэн, цаашид анхаарах асуудлуудын талаар санал солилцов. Мөн энэ баримт бичгийн хэрэгжилтийг үнэлгээний үр дүнгийн төслийг 11 дүгээр сард оролцогч талуудад танилцуулах хурлыг НҮБ-ын Суурин төлөөлөгчийн газартай хамтран зохион	100%

		бичгийн хэрэгжилтэд анхаарч, Монгол Улс дахь НҮБ-ын системийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.			анхаарах асуудлын талаар санал солилцоно.	байгуулав. НҮБ-аас Монгол Улсад 2023-2027 онд хэрэгжүүлэх “Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ” баримт бичгийн төсөл боловсруулах ажлыг эхлүүлж, 10 дугаар сард яамдын ТНБД нар, зарим агентлаг, газрын удирдлагатай цахим уулзалт хийн, мэдээлэл өгсний зэрэгцээ баримт бичгийн Алсын хараа, тэргүүлэх чиглэл тодорхойлох хэлэлцүүлгийг 11 дүгээр сарын 2-4-нд хамтран зохион байгуулав. Ирэх 5 жилд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны төлөвлөгөө буюу 2023-2027 онд хэрэгжүүлэх “Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ” баримт бичгийн төсөл боловсруулахтай холбогдуулан Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ НҮБ-ын Суурин зохицуулагч Т.Мишраг 11 дүгээр сарын 16-нд хүлээн авч уулзав. Тогтвортой хөгжлийн үндэсний хорооны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаар ГХЯ-ны ТНБД Н.Анхбаяр баримт бичгийн төсөл боловсруулах явц, стратегийн тэргүүлэх чиглэл, хүрэх үр дүнг үндэсний хорооны хуралдаанд танилцуулж, энэ асуудлаар үндэсний хорооны хуралдааны шийдвэр гаргуулав.	
41		5. Тогтвортой хөгжлийн асуудлаар зохион байгуулагдах хурал, арга хэмжээнд оролцож, тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилтээр манай талаас хэрэгжүүлж буй бодлого, үйл	2021 - 2024		Тогтвортой хөгжлийн асуудлаар зохион байгуулагдах хурал, арга хэмжээнд тогтмол оролцож, хэрэгжилтээ тайлагнах, туршлага хуримтлуулах ач	Энэ оны 3 дугаар сард болсон Ази, Номхон далайн бүсийн тогтвортой хөгжлийн асуудлаарх 8 дугаар уулзалтад Үндэсний хөгжлийн газрын дэд дарга Б.Булганчимэг оролцоход дэмжлэг үзүүлэв. Мөн 7 дугаар сард 6-15-ны өдрүүдэд Нью-Йорк хотноо болсон Тогтвортой хөгжлийн асуудлаарх улс төрийн өндөр түвшний уулзалтад Үндэсний хөгжлийн газрын дэд дарга Б.Булганчимэг, тус газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга С.Сюзанна нар оролцоход дэмжлэг үзүүлэв. Энэ үеэр “Sustainable Pastoralism and Rangelands: Impacts of COVID, and how to leave them behind in the 2030 Agenda for Sustainable Development” сэдэвт тусгай арга хэмжээ зохион байгуулж, манай улсын дэвшүүлсэн “Бэлчээр	100%

		ажиллагааг танилцуулж, Тогтвортой хөгжлийн асуудлаарх манай талын Сайн дурын үндэсний илтгэлийг танилцуулах талаар дэмжлэг үзүүлж ажиллана.			холбогдолтой.	болон нүүдлийн мал аж ахуйн олон улсын жил” санаачилгын талаар танилцуулав.	
42		6. Монгол Улс, ОХУ-ын хооронд 1958 болон 1976 онд байгуулсан хилийг гэрээг НҮБ-д бүртгүүлэх чиглэлээр ажиллана	2021 - 2022		Нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал баталгаажиж, гадаад аюулгүй байдал бэхжинэ.	Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг ОХУ-ын Гадаад хэргийн сайд Лавровын урилгаар 2021.05.31-06.04-ний өдрийн хооронд ОХУ-д албан ёсны айлчлалын хийх үеэр талууд хилийн гэрээг НҮБ-д бүртгүүлэх асуудлаар санал солилцсон. Оросын талаас хоёр улсын хилийн гэрээний хавсралтыг нууцын зэрэглэлээс гаргах дотоодын хуулийн шаардлагыг хангах ажлыг эхлүүлсэн бөгөөд тодорхой хугацаа шаардлагатай талаар мэдэгдэж, уг асуудлаар хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлсэн. Түүнчлэн уг ажлыг Монгол-Оросын улсын хилийг хоёр дахь удаа хамтран шалгах ажилтай уялдуулах талаар оросын талаас мэдэгдсэн. Үүний дагуу Монгол-Оросын улсын хилийг шалгах хамтарсан комисс байгуулах саналыг оросын талд тавьсан. Гадаад харилцааны сайдын тушаалаар бэлтгэл хангах ажлын хэсгийг байгуулж, 2 удаагийн хуралдаан зохион байгуулсан. Монгол-Оросын улсын хилийг шалгах хамтарсан комиссын үйл ажиллагааны дүрмийн төслийг холбогдох байгууллагуудад уламжилж, санал авсны үндсэн дээр уг төслийг хүлээн зөвшөөрч буй талаар 2021.10.28-ны өдрийн А/21-996 тоот ноот бичгээр оросын талд мэдэгдэж, хамтран комиссын анхдугаар хуралдааныг 2021 онд багтаан зохион	70%

						байгуулах тов тохиролцох санал тавьсан. Оросын талаас дотоодын хуулийн шаардлагыг хангах ажлыг дуусгаагүй байгаа тул 2022 оны эхний улиралд хийх санал ирүүлсэн. Засгийн газрын 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 289 дүгээр тогтоолоор Монгол Улс, ОХУ хоорондын улсын хилийг шалгах хамтарсан комиссын Монголын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын удирдамж, орон тоог баталсан. Удирдамжид Монгол Улс, ОХУ хоорондын 1958, 1976 оны хилийн гэрээг НҮБ-д бүртгүүлэх бэлтгэлийг хангах талаар тусгасан. Удирдамжийн дагуу ажиллаж байна. Хил шалгах ажилтай уялдуулан 1958, 1976 оны хилийн гэрээг нуцын зэрэглэлээс гаргах дотоодын ажлын хэсэг байгуулах талаар холбогдох байгууллагуудад мэдэгдэж, ажлын хэсэгт орох албан хаагчдыг нэрсийг авч нэгтгээд байна.	
43		7. Энэтхэг, Номхон далайн санаачилгыг эдийн засгийн хамтын ажиллагаа, үр өгөөж, ач холбогдол талаас нь судалж, хамтран ажиллах боломжийг эрэлхийлнэ.	2021 - 2024		Худалдаа, эдийн засгийн харилцаа нэмэгдэж, тодорхой төсөл, хөтөлбөр хэрэгжих боломж бүрдэнэ.	АНУ-ын дэвшүүлж буй “Энэтхэг-Номхон далайн стратеги”, Япон Улсын дэвшүүлж буй “Чөлөөт, нээлттэй Энэтхэг-Номхон далайн санаачилга”-ын тухай, мөн цаашдын өрнөлийн талаарх мэдээллийг ҮАБЗ, болон бусад холбогдох газруудад тогтмол хүргүүлж ажилласан. Монгол, АНУ, Японы гурван талт уулзалтын мөрөөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар дахь АНУ, Японы ЭСЯ-ны Элчин зөвлөхүүдтэй манай талын санаачилгаар 2021 оны 2 дугаар сард уулзаж, “Энэтхэг-Номхон далайн үзэл санаа”-ны хүрээнд Монгол, АНУ, Японы гурван талт хамтын ажиллагааны хэлбэрээр хэрэгжүүлж болох төсөл хөтөлбөрүүдийн талаар санал солилцсон. 2021 оны 7 дугаар сард Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Япон Улсад айлчлах үеэр Япон Улсын Ерөнхий сайд Ё.Суга-тай уулзаж “Чөлөөт, нээлттэй Энэтхэг-Номхон далайн санаачилга”-ын хүрээнд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн талаар санал солилцсон. Цаашид “Энэтхэг-Номхон далайн үзэл	70%

						санаа”-ны хүрээнд АНУ, Япон Улстай кибер аюулгүй байдал, харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж ажиллах зарчмын тохиролцоонд хүрсэн. 2022 онд Улаанбаатар хотноо зохион байгуулахаар төлөвлөж буй Монгол, АНУ, Японы гурван талт уулзалтыг үеэр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн талаар дэлгэрэнгүй санал солилцож ажиллахаар төлөвлөж байна.	
44		8. НҮБ-ын бизнес ба хүний эрхийн удирдах зарчмыг хэрэгжүүлэх үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулна.	2020 - 2024	Улсын төсвөөс зардал гаргаагүй. Төлөвлөгөө боловсруулах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны зардлыг НҮБХХ-тэй хамтран хэрэгжүүлж буй “Бизнес ба хүний эрх” төслийн хөрөнгөөр санхүүжүүлсэн /ойролцоогоор 30,000 ам.доллар/	Нэгдэн орсон олон улсын гэрээ, хэрэлцээрийн хяналт сайжирч хэрэгжилт хангагдана.	НҮБ-ын Бизнес ба хүний эрхийн удирдах зарчмыг хэрэгжүүлэх үндэсний төлөвлөгөө боловсруулах үйл явцыг урагшлуулах чиглэлээр ажиллав. Төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн Гүйцэтгэх хорооны хурал (2021.03.10), ажлын хэсгийн хурал (2021.07.02, 2021.10.22)-ыг зохион байгуулж, 2021 онд хэрэгжүүлэх ажил, явц, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэж ажиллав. НҮБХХ-өөс ЕХ-той хамтран Ази, Номхон далайн бүс нутагт 2017-2023 онд хэрэгжүүлж буй “Бизнес ба хүний эрх: Хамгаалах, хүндэтгэх, зөрчигдсөн эрхийг сэргээх механизмаар дамжуулан эдийн засгийн өсөлтийг дэмжих нь” (B+HR Asia) хөтөлбөрт Монгол Улсыг хамруулах хүсэлтийг холбогдох талуудад тавьж, идэвхтэй ажилласны дүнд манай улс уг хөтөлбөрт 2021.02.01-ний өдрөөс хамрагдаж эхлэв. Төслийн нээлтийн үйл ажиллагааг 2021.04.29-ний өдөр цахимаар зохион байгуулав. Үндэсний төлөвлөгөөнд тусгах салбар, чиглэлийг тодорхойлох зорилгоор 2021 оны 4 дүгээр сараас 11 дүгээр сарын хооронд НҮБХХ, МҮХАҮТ болон холбогдох бусад талтай хамтран нийт удаагийн 17 хэлэлцүүлэг зохион байгуулав. Мөн төв, зүүн болон говийн бүсийн аймгуудын 2 бүсчилсэн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Түүний зэрэгцээ үндэсний урьдчилсан суурь үнэлгээний дүнг баталгаажуулах зорилгоор түүврийн тоон судалгаа авах ажлыг гүйцэтгэж байна. Цаашид бусад сэдэвчилсэн болон	90%

						бүс нутгийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлэх, зарим нэмэлт судалгааг хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна. Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж салбар хэлэлцүүлэг зэрэг зарим төлөвлөгөөт ажил хойшилсон ч хэлэлцүүлгүүдээс гарах санал, зөвлөмжийг үндэслэн үндэсний суурь үнэлгээний төслийг эцэслэх, төлөвлөгөөний төсөл боловсруулах ажлыг 2022 оны эхний хагаст хэрэгжүүлж, Засгийн газрын хуралдаанд танилцуулж хэлэлцүүлэхээр зорьж байна.	
45	4.5.7. Монгол Улсын гадаад бодлого, харилцааны нэгдмэл байдлыг хангах, залгамж чанарыг хадгалах, төр, засгийн байгууллагын гадаад харилцааг нэгдсэн байдлаар зохицуулах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	1. Гадаад бодлогын тухай хуулийн төслийг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, УИХ-аар хэлэлцүүлнэ.	2021 - 2022		Гадаад бодлого нэг цонхоор хэрэгжих боломж бүрдэнэ. 30%	ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн А/68 дугаар тушаалаар “Монгол Улсын гадаад бодлого, харилцааны нэгдмэл байдлыг хангах, залгамж чанарыг хадгалах, төр засгийн байгууллагын гадаад харилцааг нэгдмэл байдлаар зохицуулах тухай” хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. ГХЯ-нд ХШҮДАГ-ын захирлаар ахлуулсан ажлын хэсэг ажиллаж, “Монгол Улсын төрийн төрийн гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангах тухай хууль” болон үзэл баримтлалын төслийг боловсруулж ГХЯ-ны газар, нэгжийн удирдлагын түвшинд хэлэлцүүлж, саналыг тусган 2021 оны 1 дүгээр сард Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан. Мөн Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийг боловсруулахтай холбогдох судалгааг хийж гүйцэтгэсэн. Одоо гадаад бодлого, харилцааны нэгдмэл байдлыг хангах, төр, засгийн байгууллагын гадаад харилцааг нэгдсэн байдлаар зохицуулах чиг үүргийг “Дипломат албаны тухай хууль”-д тусгахаар санал боловсруулж байна.	50%
46	4.5.8. Улс төр, эдийн засгийн харилцааны түвшин, ач	1. Дараах ДТГ-уудын байршил, бүтэц, орон тоог тогтооход эхний	2021 - 2024	Улсын төсвөөс 16917.56 ам доллар буюу	Гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын	ын 2019 оны 80 дугаар тогтоолоор Арабын Нэгдсэн Эмират Улсын нийслэл Абу Даби хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулахаар шийдвэрлэсэн бөгөөд 2021 оны III улиралд Монгол	90%

	холбогдол, тухайн улсад оршин суугаа монгол иргэд болон харилцан зорчиж байгаа иргэдийн тоо зэргийг харгалзан Дипломат төлөөлөгчийн газруудын байршил, бүтэц, орон тоог оновчтой болгоно.	ээлжинд анхаарч ажиллана. Үүнд: -Арабын Нэгдсэн Эмират Улсад Монгол Улсын Элчин сайдын яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Манжуур, Америкийн Нэгдсэн Улсын Чикаго хотод Консулын газар нээнэ. -Монгол Улсаас Шведийн Хаант Улс, Бүгд Найрамдах Чех Улс, Австралийн Холбооны Улс, Бүгд Найрамдах Франц Улсад суугаа Элчин сайдын яамдын бүтэц орон тоог оновчтой болгох, бэхжүүлэх хүрээнд Консулын хэлтэс байгуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна. -ДТГ-уудын байршил бүтэц орон тооны асуудлыг ач		47,594,002.37 сая төгрөг зарцуулсан.	таатай орчин бүрдэнэ. Тухайн орнуудтай харилцаа, хамтын ажиллагаа өргөжин хөгжинө.	Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар тус улсад суух Элчин сайд, ГХЯ-ны дэргэдэх ТАСЗ-ийн шийдвэрээр тус ЭСЯ-нд ажиллах албан хаагчид томилогдсон. Элчин сайд болон ЭСЯ-ны албан хаагчид 2021 оны 11, 12 дугаар саруудад суух орон руу явсан бөгөөд 2021 оны 12 дугаар сард багтаан ЭСЯ-ыг нээн ажиллуулахаар бэлтгэлийг хангаж байна. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Манжуур хотод 2020 оны 10 дугаар сарын 15-нд Консулын газрын үйл ажиллагааг нээж, батлагдсан орон тооны хүрээнд консул, 2021 оны 4 дүгээр сард консулын техник ажилтан, ААЭЖ-ийг тус тус томилоод байна. Америкийн Нэгдсэн Улсын Чикаго хотод Консулын газар нээх асуудлыг Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд УИХ-ын 2021 оны 64 дүгээр тогтоолоор Америкийн Нэгдсэн Улсын Чикаго хотод Консулын газрыг нээн ажиллуулах тухай шийдвэр гаргуулсан. Тус Консулын газарт томилогдон ажиллах Консул болон бусад дипломат, техник ажилтнуудыг ТАСЗ-ийн 2021 оны 10, 11 дүгээр сарын хуралдаанаар шийдвэрлэсэн бөгөөд одоогоор эдгээр албан хаагчдыг суух улс руу томилон явуулах бэлтгэл ажлыг хангаж байна. Түүнчлэн, Вашингтон дахь ЭСЯ-аар дамжуулан КГ-ын байрыг сонгон айлын талаас холбогдох зөвшөөрлийг авсан бөгөөд КГ-ын үйл ажиллагааг 2022 оны I улиралд багтаан нээн ажиллуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Монгол Улсаас Австралийн Холбооны Улс, Монгол Улсаас Шведийн Хаант Улс, Бүгд Найрамдах Чех Улсад суугаа ЭСЯ-нд консулын хэлтэс нээх бэлтгэлийг ханган ажиллаж байна. Цар тахлын улмаас консулын хэлтэс нээх ажил удаашралтай байна. Бүгд Найрамдах Франц Улсад суугаа Элчин сайдын яамны бүтэцэд Консулын хэлтэс байгуулах асуудлыг 2024	

		холбогдлыг нь харгалзан тухай бүр шийдвэрлэнэ.				онд багтаан шийдвэрлэхээр төлөвлөж байгаа болно.	
47		2. Дипломат албан хаагчдыг сонгон шалгаруулах, томилохдоо ил тод байдлыг хангаж, тухайн албан тушаалд тавигдах мэргэжлийн мэдлэг, ур чадвар, туршлага болон гадаад хэлний шаардлагыг чанд мөрдөж ажиллана.	2021 - 2024		Дипломат албаны боловсон хүчний чадавх, ур чадвар сайжирна.	2021 онд хилийн чанад дахь ДТГ-т 47 албан хаагчийг дипломат албан тушаалд, 27 албан хаагчийг үйлчилгээ техникийн ажилтнаар тус тус томилох асуудлыг шийдвэрлэв. Дипломат албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т “Дипломат албанд орох иргэнийг сонгон авах болзлыг гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэж заасны дагуу Гадаад харилцааны сайдын 2020 оны А/03 дугаар тушаалаар “Дипломат албанд орох иргэнийг сонгон авах болзол”-ыг баталсан. Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, 27.1.3 дахь заалт, “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 2.1, 2.3-т заасныг үндэслэн Гадаад харилцааны яамны гүйцэтгэх албан тушаал /атташе/-ын сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар дамжуулан зарласан. Нийт 51 иргэд сонгон шалгаруулалтад орсноос 32 албан хаагч шалгалтад тэнцэж Гадаад харилцааны яамны газар, нэгжид томилогдон ажиллаж байна.	100%
48	4.5.9. Дипломат албанд сахилга, хариуцлагыг эрс нэмэгдүүлж, хар тамхи тээвэрлэх болон хууль бус бусад аливаа үйлдлийг	1. Дипломат албаны ёс зүй, сахилга бат, үүрэг, хариуцлагыг өндөржүүлж, ёс зүйн болон сахилгын зөрчил гаргасан албан хаагчдад тухай бүр хариуцлага	2021 - 2024		Дипломат албан хаагчийн сахилга, хариуцлага сайжирна. Гадаад харилцааны салбарын нэр хүнд өснө.	Төрийн албаны тухай, Дипломат албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Дипломат ажилтны сахилгын тусгай дүрэм зэрэг тогтоомжоор хүлээсэн үүрэг, тогтоосон хориглолт, хязгаарлалтыг чанд мөрдөж, хэрэг зөрчилд холбогдохгүй байхыг нийт албан хаагчдад анхааруулсан чиглэл, анхааруулга хүргүүлэх, сургалт зохион байгуулах арга хэмжээг тогтмол авч ажиллав. Тухайлбал, Ерөнхийлөгчийн 2021 оны сонгууль зохион байгуулахтай холбогдуулж,	100%

	таслан зогсооно.	хүлээлгэнэ.				хуулиар хориглосон үйлдэл гаргахгүй байх, чанд мөрдөж ажиллах чиглэлийг нийт ДТГ-т хүргүүлсэн. Түүнчлэн ДТГ-уудад ажиллахаар томилогдсон албан хаагчдад зориулсан хууль эрх зүй, сахилга хариуцлага, дипломат ёслол болон бусад улс төр, эдийн засгийн сэдвээрх сургалтыг 2021.06.07-ны өдөр, шинээр томилогдсон 23 Элчин сайдад зориулсан тусгай хөтөлбөрийн дагуу 2021 оны 7 дугаар сард цуврал сургалтуудыг зохион байгуулсан. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Гадаад харилцааны сайдаас өгсөн үүргийн дагуу “Ажлын байран дахь бэлгийн дарамтын талаарх мэдлэг, ойлголт, хандлага, нөхцөл байдлыг тандан судлах” асуулга боловсруулан, салбарын нийт 600 орчим албан хаагчдын хамруулсан судалгаа явуулж, үр дүнг удирдлагад танилцуулсан. Түүнчлэн, ДТГ-ын тэргүүн нарт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээ болон авсан арга хэмжээний тухай эргэн мэдэгдэх үүрэг чиглэлийг хүргүүлсэн. Вена, Софи, Брюссель дахь ЭСЯ-дын акталсан автомашин суурилуулсан байсан байршил тогтоогч төхөөрөмж /GPS/- шинээр худалдан авсан автомашинуудад суурилуулж, ашиглалтад оруулсан. 2021 онд хилийн чанад дахь зарим ДТГ-уудын 10 тээврийн хэрэгсэлт шинээр байршил тогтоогч төхөөрөмж /GPS/-ийг суурилуулахаар төлөвлөж байсан боловч цар тахлаас үүдсэн хилийн хязгаарлалтын улмаас уг ажлыг хэрэгжүүлэх боломжгүй болсон.	
49		2. Хар тамхи, хууль бус наймаанд оролцсон ажилтан, түүнийг	2021 - 2024		Дипломат албан хаагч хилийн чанадад хууль бус наймаанд оролцдог, хэрэг,	Засгийн газрын 2019 оны 272 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дипломат ажилтны сахилгын тусгай дүрэм”-д ДТГ-т ажиллах хугацаандаа хууль бус наймаанд нэр холбогдсон, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис (хар тамхи)-ыг хууль	100%

		хариуцан ажиллаж буй ДТГ-ын тэргүүнийг эгүүлэн татах эрх зүйн орчныг бүрдүүлэн, мөрдөж ажиллана.			зөрчилд холбогддог байдал арилна.	бусаар олж авах, бэлтгэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, олон улсын хил, гаалиар нэвтрүүлэх буюу нэвтрүүлэхийг завдах үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцсон нь тогтоогдсон болон суугаа улсын холбогдох байгууллагаас ДТГ-т албан ёсоор мэдэгдсэн тохиолдолд тухайн албан хаагчийг дипломат албанаас халах, түүнчлэн тухайн ажилтныг удирдан ажиллаж буй ДТГ-ын тэргүүнд мөн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг тусгасан. Тайлангийн хугацаанд энэ төрлийн хэрэг зөрчил гараагүй.	
50		3. Засгийн газрын 2019 оны 272 дугаар тогтоолоор баталсан Дипломат ажилтны сахилгын тусгай дүрмийг чанд мөрдөж, эрсдлээс урьдчилан сэргийлэх сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна.	2021 - 2024		Дипломат албан хаагч хэрэг зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлнэ.	Төрийн болон дипломат албаны эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Төрийн албаны тухай, Дипломат албаны тухай хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг, тогтоосон хориг хязгаарлалтыг чанд мөрдөх, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэхэд онцгой анхаарч ажиллахыг нийт албан хаагчдад анхааруулан ажиллаж байна. Хилийн чанад дахь ДТГ-уудад ажиллахаар томилогдсон 63 албан хаагчийг 2021.06.07-ны өдөр “Хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газарт ажиллаж буй албан хаагчдын эрх үүрэг, хариуцлагын тухай” сургалтад хамруулав. Мөн ТАЗ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн хүрээнд 2021.08.26-ны өдөр зохион байгуулагдсан “Ёс зүйн зөвлөлүүдийг чадавхжуулах нь” сэдэвт сургалтад тус яамны Ёс зүйн зөвлөлийн гишүүд хамрагдаж, арга зүйн зөвлөгөө мэдээлэл авав. Соён гэгээрүүлэх чиглэлээр хийсэн сургалт: 1. Дипломат төлөөлөгчийн газруудад шинээр томилогдсон албан хаагчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд ДТГ-т ажиллаж байх хугацаандаа баримтлах сахилга хариуцлага, ёслол хүндэтгэл, санхүү төсөв болон салбарын хөдөлмөрийн дотоод	100%

						журам, сахилгын тусгай дүрэм зэрэг сэдвүүдээр дэлгэрэнгүй багц сургалт зохион байгуулав. 2. 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр яамны гүйцэтгэх албан хаагчдыг цахимаар болон танхимаар Жендэрийн үндэсний хороотой хамтран төрийн албан хаагчийн ёс зүй, ажлын байрны бэлгийн дарамт сэдвээр ГХЯ-ны нийт албан хаагчдад сургалт зохион байгуулав. 3. ГХЯ-ны 2021 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг ГХС-аар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд шинээр ажилд орсон албан хаагчдад зориулсан Авлигын эсрэг сургалтыг цахимаар зохион байгуулсан.	
51	4.5.10. Монгол Улсын түүх, соёл, өв уламжлал, үнэт зүйлсээ олон улсад сурталчлах, таниулах "Монгол Үндэстний үнэлэмж" арга хэмжээ, хилийн чанадад байгаа иргэд монгол хэл, соёл, өв уламжлал, үнэт зүйлсээ хадгалан тээх "Дэлхийн Монголчууд II" арга хэмжээг төлөвлөн боловсруулж	1. Монгол Улсын эерэг имижийг бүрдүүлэх, нэр хүндийг өсгөх замаар улс орныхоо язгуур эрх ашгийг хамгаалах, байр суурийг бэхжүүлэхэд зөөлөн хүчний бодлогыг хэрэгжүүлэх зорилготой "Монгол Үндэстний үнэлэмж" арга хэмжээ хэрэгжүүлнэ.	2021 - 2024		Монгол Улс, Монгол хүний үнэлэмж, нэр хүнд гадаад улсад өснө. Зөөлөн хүчний бодлого бодитоор хэрэгжинэ. Эдийн засгийн ач холбогдолтой.	"Монгол Үндэстний үнэлэмж” цогц арга хэмжээний төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.1.3-ын дагуу боловсруулж, баримт бичгүүдийн уялдаа, Нөлөөллийн урьдчилсан үнэлгээ, Нөхцөл байдлын дүн шинжилгээ, Үр дүнгийн үзүүлэлт, Төсвийн тооцоо зэрэг 5 цогц судалгаа, тайлан, тооцооллыг 2021 оны 1 дүгээр улиралд хийж гүйцэтгэв. Цогц арга хэмжээний төсөлд 2021.04.09-ний 11/1579 тоотоор холбогдох 17 яам, газрууд болон нийт 40 ДТГ-аас санал авч тусгав. ЗГХЭГ-ын даргын 2021.07.24-ний 50 дугаар тушаалаар батлагдсан Хөгжлийн зорилтот хөтөлбөр боловсруулах ажлын хэсгээс гарах Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн жагсаалтад "Монгол Үндэстний үнэлэмж" цогц арга хэмжээг тусгуулахаар ажиллаж байна. Энэ хугацаанд ЗГХЭГ-ийн 2021 оны ХЭГ/1432 тоот албан бичигт “Цогц арга хэмжээ нь хөгжлийн зорилтот хөтөлбөрт хамрагдах бөгөөд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5 болон 13.3 дахь хэсэгт заасны дагуу зохицуулагдах” гэж заасны дагуу ГХ-ны сайдын 2021.10.20-ны А/64 дугаар тушаалаар цогц арга хэмжээг батлав. ГХЯ-ны хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан,	70%

	хэрэгжүүлнэ.					хэрэгжүүлэв. Санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр 2021.08.20-ны 08/3609 тоот албан бичгээр “Монгол Үндэстний үнэлэмж” цогц арга хэмжээг 2022 онд хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг ГХЯ-ны төсөвт нэмж тусгаж өгөх хүсэлтийг Б.Батцэцэг сайдаас Сангийн сайд Б.Жавхланд хүргүүлж, 2021.09.11-12-нд ЗГХЭГ-аас зохион байгуулсан “Монгол Улсын 2022 оны төсвийн төсөөллийн талаарх хэлэлцүүлэг”-т ГХ-ны сайд Б.Батцэцэг “Монгол Үндэстний үнэлэмж” цогц арга хэмжээний талаар танилцуулж, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг хүсэв. Цогц арга хэмжээг 2022 онд хэрэгжүүлэхэд шаардагдах 7,8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Засгийн газрын 2021.06.30-ны өдрийн 178 дугаар тогтоолоор батлав. Цогц арга хэмжээний хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Зөвлөлийн бүрэлдэхүүнийг ГХ-ны сайдын 2021.12.03-ны А/73 дугаар тушаалаар батлан, Зөвлөлийн хурлыг 2021.12.24-нд өдөр зохион байгуулав.	
52		2. Хилийн чанадад байгаа иргэд монгол хэл, соёл, өв уламжлал, үнэт зүйлсээ хадгалан тээх "Дэлхийн Монголчууд II" арга хэмжээ /хөтөлбөр/ боловсруулж хэрэгжүүлнэ.	2021 - 2024		Хилийн чанадад байгаа иргэд Монгол Улсаа сурталчлах, түүх, хэл, соёл, өв уламжлал, үнэт зүйлсээ тээн түгээж, хойч үедээ өвлүүлэн үлдээнэ.Улс орныхоо эдийн засагт хувь нэмэр оруулах боломж	2021 оны 4 дүгээр сарын 20-ний өдрийн 11/1679 тоот албан бичгээр “Дэлхийн монголчууд-II” цогц арга хэмжээний төсөл, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл болон тогтоолын төсөл, төсвийн тооцоо зэрэг баримт бичгийг ЗГХЭГ-т хүргүүлэв. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2021 оны 5 дугаар сарын 28-ны өдөр хилийн чанад дахь Монгол иргэдтэй хийсэн цахим уулзалтын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд “Дэлхийн монголчууд-II” цогц арга хэмжээг батлуулж, хэрэгжүүлэх тухай заалт тусгасан. Уг цахим уулзалтын Илтгэх хуудас, Мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө болон “Дэлхийн монголчууд-II” цогц арга хэмжээний төсөл, санхүүжилтийн тооцоолол зэргийг 2021 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 11/3172 тоот	70%

					нэмэгдэнэ.	албан бичгээр Ерөнхий сайдын Ажлын албанд хүргүүлж, цогц арга хэмжээг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд дэмжлэг хүсэв. 2021 оны 8 дугаар сарын 20-ны 08/3609 тоот албан бичгээр “Монгол Үндэстний үнэлэмж” болон “Дэлхийн Монголчууд-II” цогц арга хэмжээг 2022 онд хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг ГХЯ-ны төсөвт нэмж тусгаж өгөх хүсэлтийг Сангийн сайд Б.Жавхланд Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгээс хүргүүлэв. 2021 оны 9 дүгээр сарын 11-12-нд ЗГХЭГ-аас зохион байгуулсан “Монгол Улсын 2022 оны төсвийн төсөөллийн талаарх хэлэлцүүлэг”-т Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг “Монгол Үндэстний үнэлэмж” болон “Дэлхийн Монголчууд-II” цогц арга хэмжээний талаар танилцуулж, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг хүсэв. “Дэлхийн Монголчууд-II” цогц арга хэмжээг Гадаад харилцааны сайдын 2021 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн А/51 дугаар тушаалаар баталж, цогц арга хэмжээний хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Гадаад харилцааны сайдын 2021.12.01-ний А/71 дугаар тушаалаар батлав.	
ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
53	6.1.10. Улаанбаатар хотын цэвэр усны шинэ эх үүсвэрийг бий болгож, "Төв цэвэрлэх байгууламж"-ийг шинээр барьж	1. АНУ-ын МСК-ын бүцалтгүй тусламжийн хөрөнгөөр Улаанбаатар хотын ус хангамжийн баруун эх үүсвэрийг барьж, ашиглалтад	2021 - 2024		Төслийн хэрэгжилт 6 хувьд хүрнэ.	Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг АНУ-ын Мянганы сорилтын корпорацын Компакт гэрээний үйл ажиллагаа хариуцсан Дэд ерөнхийлөгч Фатима Сумартай цахим уулзалт хийсэн. Монгол Улсын Засгийн газар АНУ-ын Мянганы сорилтын корпорацын хооронд байгуулсан Хоёр дахь Компакт гэрээг хүчин төгөлдөр болсныг тэмдэглэх арга хэмжээг 2021 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр ГХЯ-нд зохион байгуулсан. Компакт гэрээний хүрээнд хаягдал усыг дахин боловсруулах үйлдвэр, ус гүн цэвэршүүлэх үйлдвэр	100%

	ашиглалтад оруулан, тус цэвэрлэх байгууламжаар цэвэрлэгдсэн усыг дулааны III, IV цахилгаан станцын технологийн хэрэгцээнд ашиглана. Монгол Улсад мөрдөгдөж байгаа стандартад нийцсэн бие даасан цэвэрлэх байгууламж бүхий ноолуурын үйлдвэрүүдээс бусдыг хотоос гаргаж, Ус сувгийн удирдах газрын харьяа урьдчилсан цэвэрлэх байгууламж Харгиаг татан буулгана.	оруулна.				тус тус баригдана. Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр байгуулах, СКАДА систем суурилуулах ажлын гэрээг БНТУ-ын МАПА Иншаат Тиажарет ХХК-тай 2021 оны 8 дугаар сарын 2-ны өдөр байгуулсан. Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн шав тавих ёслол 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдөр болсон. Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийг барих ажлыг гүйцэтгэж байгаа МАПА Иншаат Тиажарет ХХК нь газар шорооны ажил, түр цахилгаан хангамж, түр барилгын суурь, үерийн ус зайлуулах 1500мм диаметртэй бетон шугамын суурилуулалт зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Компактын хүрээнд хэрэгжүүлэх томоохон ажлуудын нэг болох “Газрын доорх усны эх үүсвэрийн худгууд, ус дамжуулах шугам хоолойн барилга угсралтын ажил”-ын гүйцэтгэгчийг олон улсын нээлттэй тендер зарлан сонгон шалгаруулахаар ажиллаж байна. Ус дахин боловсруулах үйлдвэрийн зураг төслийн болон барилгын ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг зарлан 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл тендерийн материалыг хүлээн авч байна. Ус дамжуулах шугам хоолой, холбогдох дэд бүтэц, ДЦС-3, ДЦС-4 ТӨХК-ийн техникийн усны схемийн өөрчлөлтийн зураг төсөл боловсруулах, Хаягдал ус дахин боловсруулах төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ болон Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийх, ус дамжуулах шугам хоолойн трассын дагуу Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулах ажлуудыг гүйцэтгэх ХБНГУ-ын Фихтнер Вотер Транспортэйшн ХХК-тай гэрээ байгуулж, ажлыг эхлүүлээд байна.	